



ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025.07.08

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Зарцуулсан төсөв /сая/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Үнэлгээ
Яамны стратегийн зорилт 1. Харилцаа холбоо, инновац, гарааны бизнес, их өгөгдөл, хиймэл оюун ухаан, мэдээллийн технологи, шуудан, өргөн нэвтрүүлэг, радио давтамж, сансрын технологи, кибер аюулгүй байдлыг хангах хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, урт болон дунд хугацааны стратегийн төлөвлөгөө боловсруулах, шаардагдах судалгаа шинжилгээ хийх, хөгжлийн бодлогын уялдааг хангах, бодлогын удирдамжаар хангах, хууль эрх зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх							
	Зорилт 1. Харилцаа холбоо, шуудан, өргөн нэвтрүүлгийн хөгжлийн бодлого, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангана.	-	Хүргүүлсэн баримт бичгийн тоо Батлуулсан баримт бичгийн тоо	0 0	3 3	Хүргүүлсэн баримт бичгийн тоо 4 Арга хэмжээний тоо 4	
1	Арга хэмжээ 1.1. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газарт хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн хуулийн төслийн тоо	0	1	Уг ажлыг 4 дүгээр улиралд бүрэн хэрэгжүүлж дуусах ба 2025 оны эхний хагас жилийн байдлаар хуулийн төсөл боловсруулахтай холбогдуулан Бүгд Найрамдах Солонгос Улсын Цахилгаан холбооны эрх зүйн байдлыг зохицуулсан хуулиудыг судалсан. Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл болон хуулийн төслийг боловсруулж дууссан. Хагас жилийн байдлаар гүйцэтгэх ажил бүрэн биелэгдсэн бөгөөд одоогоор хуулийн төслийг эцэслэж санал авах шатанд ажиллаж байна.	90
2	Арга хэмжээ 1.2. Шуудангийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газарт хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн хуулийн төслийн тоо	0	1	Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой санал боловсруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/73 дугаар тушаалаар байгуулсан. Тус ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 06, 16-ны өдрүүдэд Улсын Их Хурлын Инновац цахим бодлогын байнгын хороонд Шуудангийн тухай хуулийн хэрэгжилт болон тус хуульд нэмэлт өөрчлөлт оруулах талаар мэдээлэл хийсэн. Мөн шуудангийн үйлчилгээ үзүүлэгч оролцогч талуудаас хуулийн нэмэлт өөрчлөлтөд оруулах санал болон Шуудан, цахим худалдааны бодлого, зохицуулалтын үйл ажиллагаанд тусгах санал авахаар шуудангийн үйлчилгээ үзүүлэгч 24 байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 01/1278 дугаартай албан бичиг хүргүүлэн саналыг хүлээн авч ажиллаж байна. Өөрөөр хэлбэл эхний хагас жилийн байдлаар төлөвлөгдсөн ажлын биелэлт хангалттай хэрэгжсэн. Санал нэгтгэгдсэний дараа Засгийн газрын хэрэг эрхлэх газарт саналыг тусган хүргүүлэхээр төлөвлөж байна.	100
3	Арга хэмжээ 1.3. Дэлхийн шуудан холбооны дүрмийн 11 дүгээр нэмэлт протоколыг соёрхон батлахтай холбоотой материалыг боловсруулан Засгийн газарт хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1	Дэлхийн шуудан холбооны дүрмийн 11 дүгээр нэмэлт протоколыг соёрхон батлах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан нийт 20 байгууллагын саналыг авч нэгтгэсэн. Мөн Гадаад харилцааны яам, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яамдаас хэлэлцүүлэх зөвшөөрлийг авч, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Хуулийн үзэл баримтлалын төслийг боловсруулан Гадаад харилцааны сайдаар батлуулсан. Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулахаар хүргүүлсэн боловч тус хуулийн холбогдох судалгааг боловсруулан ирүүлэх хүсэлтийн дагуу хуулийн төслийг батлуулахад шаардагдах судалгааг боловсруулан ажиллаж байна.	70
4	Арга хэмжээ 1.4. Интернэтийн дундын холболтын журмын төсөл боловсруулж, батлуулна.	-	Батлуулсан баримт бичгийн тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй.	-
5	Арга хэмжээ 1.5. Монгол Улсын Харилцаа холбооны дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулж, батлуулна.	-	Батлуулсан баримт бичгийн тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй.	-
6	Арга хэмжээ 1.6. Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн технологи нэвтэрч байгаатай холбогдуулан 2G, 3G технологид суурилсан сүлжээ, үйлчилгээний өнөөгийн байдлын судалгааг хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулна.	-	Боловсруулсан баримт бичгийн тоо	0	1	Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн технологи нэвтэрч байгаатай холбогдуулан 2G, 3G технологид суурилсан сүлжээ, үйлчилгээний өнөөгийн байдлын судалгааг хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал, зөвлөмж боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/45 дугаар тушаалаар батлуулсан. Ажлын хэсгийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу судалгааны асуулгыг боловсруулж, асуулгын хүрээнд 2G болон 3G сүлжээний өнөөгийн байдлын судалгааг хот, аймаг, сум, суурин газрын түвшинд хийж, санал дүгнэлт боловсруулсан. Судалгаанд үндэслэн хөдөлгөөнт холбооны 2G болон 3G сүлжээг зогсооход баримтлах чиглэлийн төсөл боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авч байна. Эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөний хэрэгжилт 100 хувьтай үргэлжилж байна.	100

Зорилт 2. Инновац, гарааны бизнес, их өгөгдөл, хиймэл оюун хөгжлийн бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангана.		-	Хүргүүлсэн баримт бичгийн тоо Боловсруулсан баримт бичгийн тоо	0 0	1 2	Баталсан баримт бичиг 1	
7	Арга хэмжээ 2.1. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн тухай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	-	Судалгааны тоо Хүргүүлсэн хуулийн төслийн тоо	0 0	1 1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/49 дүгээр тушаалаар "Дроны ашиглалт, хэрэглээний талаар судалж, хууль эрх зүйн орчны судалгаа хийж санал боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, эхний хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр цахимаар зохион байгуулсан. Уг хурлаар "Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн тухай хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (UAV)-ийн хууль тогтоомжийн хэрэгцээ шаардлагын урьдчилан тандан судалгаа хийх, хуулийн төсөл боловсруулах" ажлын даалгаврын төслийг танилцуулж, тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн. Уг ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/98 дугаар тушаалаар байгуулсан. Тус тендерийг 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр зарласан боловч амжилтгүй болсон тул дахин 2 дахь удаагаа 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр зарласан.	30
8	Арга хэмжээ 2.2. Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж батална	-	Боловсруулсан баримт бичгийн тоо	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль	1	Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн баримт бичиг болон урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан Засгийн газрын 2020 оны 100 дугаар тогтоолоор баталсан Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө"-ний анхны төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн 5 зорилтын хүрээнд 37 ажил, арга хэмжээ хэрэгжүүлэх стратегийн төслийг, стратегийн зорилтын шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, суурь болон зорилтот түшингийн хамт эцэслэн боловсруулж, Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 03 дугаар тогтоолоор "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги" төлөвлөгөө батлагдсан.	100
Зорилт 3. Цахим засаглалын хөгжлийн бодлого, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, бодлогын удирдамжаар хангана.		-	Хүргүүлсэн тоо Боловсруулсан баримт бичгийн тоо Арга хэмжээний тоо	0	2 2 1	Системээр олгосон тусгай зөвшөөрлийн тоо: "license.mn"-ээр 76, "e-business.mn"-ээр 44, эрх бүхий байгууллага өөрийн системээр 123	
9	Арга хэмжээ 3.1. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн ерөнхий төлөвлөлтийн төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ	-	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй.	-
10	Арга хэмжээ 3.2. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журмын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй.	-
11	Арга хэмжээ 3.3. Төрийн байгууллагын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг үе шаттайгаар цахимжуулна.	-	Цахим хэлбэрт шилжүүлсэн зөвшөөрлийн тоо	0	1	Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхтэй холбоотой өнөөгийн нөхцөл байдлын талаар танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Цахим засаглалын хэлтсийн дарга Б.Билэгдэмбэрэлтэй хамтран боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулсан ба Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэлээр "Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хөнгөвчлөх, цахим хэлбэрт шилжүүлэх, холбогдох захиргааны хэм хэмжээний актуудыг хуульд нийцүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Засгийн газрын холбогдох гишүүд, албан тушаалтанд үүрэг даалгавар өгөгдсөн. Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлснээр 2025 оны 2 дугаар улирлын байдлаар "license.mn"-ээр 76, "e-business.mn"-ээр 44, эрх бүхий байгууллага өөрийн системээр 123, уламжлалт буюу цаасан хэлбэрээр 16 тусгай зөвшөөрлийг олгож, зөвшөөрлийн нэгдсэн санд 151746 нэгж зөвшөөрлийн мэдээлэл бүртгэгдээд байна.	100
12	Арга хэмжээ 3.4. Нотариатын үйл ажиллагааг үе шаттай сайжруулна.	-	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	0	1	"Төр, хувийн хэвшлийн үйл ажиллагаанд цахим гэрээг нэвтрүүлж, хэрэглээг нэмэгдүүлэх (нотариат) судалгаа" ЦХИХХЯ/20250203039 дугаартай төслийн ажлыг даалгавар болон тус тендерийг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдрийн А/146 дугаар тушаалаар байгуулсан.	30
13	Арга хэмжээ 3.6. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бүсүүдэд, харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарынхны дунд зөвлөгөөн зохион байгуулна.	-	Зохион байгуулсан зөвлөгөөний тоо	0	1	Бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааны үеэр бүсийн цахим шилжилт, өндөр технологи нэвтрүүлэлтийн салбар хуралдааныг яамны эрхлэх асуудлын хүрээнд салбарын зорилтыг бүсийн хөгжилтэй уялдуулан бүс, орон нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 5 мега төслийн саналыг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 01/941 дугаартай албан бичгээр Монгол Улсын Шадар сайд С.Амарсайханд хүргүүлэв.	100

Зорилт 4. Салбарын урт, дунд болон богино хугацааны стратегийн төлөвлөгөө боловсруулна.			Хүргүүлсэн баримт бичгийн тоо Боловсруулсан баримт бичгийн тоо	0 0	2 1	Хүргүүлсэн баримт бичгийн тоо-2 Боловсруулсан баримт бичгийн тоо-2	
14	Арга хэмжээ 4.1. Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгуулах төсөл арга хэмжээний тооцоолол хийж, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1	Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын "Аргачлал, заавар батлах тухай" 2025 оны А/08 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах цаглавар"-ын дагуу тус ажил 06 дугаар сарын 15-ны өдрөөс хэрэгжиж эхэлнэ. Мөн Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулна" гэсэн шаардлагыг хангах төсөл байхгүй байна.	0
15	Арга хэмжээ 4.2. Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний төсөлд тусгуулах төсөл, арга хэмжээний тооцоолол хийж, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1	Тус яамнаас 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01/98 дугаартай албан бичгээр Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгуулах нийт 13 төслийн саналыг Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж, 6 төсөл, арга хэмжээ дэмжигдсэний дагуу Эдийн засаг, хөгжлийн яамны холбогдох албаны төлөөлөлтэй 2025 оны 3 дугаар сарын 11, 17-ний өдөр тус тус уулзалт зохион байгуулж, хиймэл оюун, инновацыг дэмжих чиглэлээр 3 төсөл, арга хэмжээг нэмж тусгасан. Мөн Сангийн яамнаас дээр дурдсан 6 төслийг хасах санал гаргасны дагуу холбогдох тайлбар, мэдээллийг нэгтгэн боловсруулж, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 12 дугаар хуралдааны тэмдэглэлд үндэслэн тус яамнаас хариуцан хэрэгжүүлэх нийт 25 төсөл (өмнө дэмжигдсэн 6 төсөл багтсан)-ийн төслийн саналыг шалгуур үзүүлэлт, тайлбарын хамт нэгтгэн боловсруулж, 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 01/916 дугаартай албан бичгээр Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлсэн ба Монгол Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар "Монгол Улсын хөгжлийн 2026 оны	100
16	Арга хэмжээ 4.3. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024-2028 оны стратеги төлөвлөгөө боловсруулж батална.	-	Батлуулсан баримт бичгийн тоо	0	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05 дугаар тушаалаар батлуулсан.	100
Зорилт 5. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн хөгжил, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хүний нөөцийн бодлого боловсруулах, төлөвлөлт хийнэ.		-	Батлуулсан баримт бичгийн тоо Судалгааны тоо	0 0	3 1	Батлуулсан ажлын даалгавар 2 тоо 1 Судалгааны	
17	Арга хэмжээ 5.1. Бүх нийтийн цахим ур чадвар, чадамжийг дээшлүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг шинэчлэн боловсруулан батлуулах.	-	Батлуулсан баримт бичгийн тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй	-
18	Арга хэмжээ 5.2. Төрийн албан хаагчдын цахим ур чадварыг дээшлүүлэх сургалтын хөтөлбөр боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангуулна.	-	Батлуулсан баримт бичгийн тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй	-
19	Арга хэмжээ 5.3. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хүний нөөцийн бодлогын баримтлах чиглэл боловсруулж батлуулна.	-	Батлуулсан баримт бичгийн тоо	0	1	1.Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа их дээд сургуулиудын удирдлагуудтай хамтран ажиллах, санал солилцох уулзалтыг зохион байгуулахаар 2025 оны 03/127 дугаартай албан бичгээр 23 их дээд сургуулиудад хүргүүлэв. 2.Салбарын хүний нөөцийг сургахад тулгамдаж буй асуудал, тус яамнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар танилцуулж, их дээд сургуулиудын удирдлагууд болон багш нарын төлөөллүүдтэй санал солилцох уулзалтыг 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулав. Уулзалтад Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Стратеги, бодлого, төлөвлөлтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ш.Батзаяат, Кибер аюулгүй байдлын бодлого зохицуулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Пүрэвням, Стратеги, бодлого, төлөвлөлтийн мэргэжилтэн Д.Сэлэнгэ болон их дээд сургуулиудын төлөөллүүд оролцов. 3.Хөгжлийн тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлийн чиглэл шинэчлэн батлах" тухай Засгийн газрын тогтоолын төсөлд санал боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01/858 дугаартай албан бичгээр Боловсролын яаманд хүргүүлэв. 4. Тайлант хугацаа дуусаагүй болно.	80
20	Арга хэмжээ 5.4. Төрийн үйлчилгээг цахимаар авахад иргэдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, иргэдийн цахим ур чадварыг тодорхойлох судалгаа хийх, зөвлөмж боловсруулна.	-	Судалгааны тоо	0	1	1."Төрийн үйлчилгээг цахимаар авахад иргэдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, иргэдийн цахим ур чадварыг тодорхойлох судалгаа хийх, зөвлөмж боловсруулах" ажлын даалгаврыг боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулав. 2."Төрийн үйлчилгээг цахимаар худалдан авахад иргэдэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, иргэдийн цахим ур чадварыг тодорхойлох судалгаа хийх, зөвлөмж боловсруулах ажлын даалгаврыг боловсруулах" тендер шалгаруулалтыг зохион байгуулах Үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн А/118 тушаалаар байгуулав. Тайлант хугацаа дуусаагүй.	30
Зорилт 6. Харилцаа холбоо, мэдээлэл технологийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг эрчимжүүлж, судалгаа хөгжлийн нэгдсэн тогтолцоог бий болгох ажлыг зохион байгуулах, зохицуулна.		-	Судалгааны тоо Саналын тоо Хэлэлцүүлгийн тоо	0	3 1 1	Саналын тоо 1	

21	Арга хэмжээ 6.1. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр олон улсын байгууллагуудаас гаргадаг индексийн харилцан уялдааг судалж, салбарын стратеги төлөвлөгөөнд тусгах санал, зөвлөмж боловсруулна	-	Санал, зөвлөмжийн тоо	0	1	"Мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын олон улсын индексүүдийн түвшинг тодорхойлж, анализ хийх" ЦХИХХЯ/20250603061 дугаартай судалгааны ажлын даалгаврыг боловсруулж, сонгон шалгаруулалтыг явуулсан. Сонгон шалгарсан компанитай Y/16 дугаартай гэрээ байгуулж, судалгааны ажлыг хүлээн авсан.	100
22	Арга хэмжээ 6.2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр шинээр боловсруулах болон шинэчлэх стандартад санал боловсруулж, хүргүүлнэ.	-	Саналын тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй.	0
23	Арга хэмжээ 6.3. Цахим эдийн засгийн суурь судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулна.	-	Судалгааны тоо Хэлэлцүүлгийн тоо	0	1 1	Монгол Улсын дижитал эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох, бусад орны сайн жишгийн судалгаа хийх Монгол Улсын өнөөгийн нөхцөл байдалд үнэлэлт дүгнэлт өгч, олон улсын сайн туршлагыг судлах үндсэн дээр дижитал эдийн засгийн суурь судалгааг хийж, өөрийн орны онцлогт нийцүүлэн хөгжүүлж өргөжүүлэх, үр дүнтэй стратеги боловсруулах зорилгоор "Дижитал эдийн засгийн суурь судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах" ЦХИХХЯ/20250603059 дугаартай ажлын даалгаврыг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/136 тушаалаар батлуулсан. Тендер шалгаруулалтыг зарласан. Тайлант хугацаа болоогүй.	30
24	Арга хэмжээ 6.4. Тоон гарын үсгийн хэрэглээний судалгаа хийж, зөвлөмж боловсруулна.	-	Судалгааны тоо Зөвлөмжийн тоо	0	1 1	"Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө"-д туссан "Тоон гарын үсгийн хэрэглээний судалгаа хийж, зөвлөмж боловсруулах ЦХИХХЯ/20250603060" дугаартай тендер шалгаруулалтыг зохион байгуулж, 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 06/05 дугаартай албан бичгээр төслийн гүйцэтгэлийн эцсийн тайланг хүлээн авч, 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр гэрээг дүгнэн акт үйлдэж, баталгаажуулсан.	100
25	Арга хэмжээ 6.5. Төрийн байгууллагуудад ашиглаж буй мэдээллийн технологийн шийдэл, системүүдийн нэгдсэн судалгаа хийж, зөвлөмж боловсруулна.	-	Судалгааны тоо Зөвлөмжийн тоо	0	1 1	1.Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбараас үзүүлж буй төрийн үйлчилгээг хувийн хэвшилд шилжүүлэн гүйцэтгүүлэх боломжтой санал авах тухай 2024 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 03/1270 дугаартай албан бичгийг харьяа болон салбарын байгууллагад хүргүүлсэн. Мөн тус асуудлаар хувийн хэвшлийн байгууллагаас санал авах зорилгоор 2025 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр яамны фэйсбүүк хуудсанд мэдээлэл оруулж, нийт 5 байгууллагаас санал ирүүлснийг нэгтгэсэн. 2.Тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн "Нийтийн мэдээллийн дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ хийх, зөвлөмж боловсруулах" ЦХИХХЯ/20250103058 төслийн ажлын даалгаварт "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээлэл хариуцагчийн ашиглаж байгаа, шинээр хөгжүүлж байгаа болон хөгжүүлэхээр төлөвлөсөн мэдээллийн систем, мэдээллийн сан, мэдээллийн сүлжээний нэгдсэн судалгааг сүүлийн 3 жилээр гаргаж төсөвт өртөг болон давхардлыг тогтоох" гэсэн ажлыг тусгасан болно.	100
Зорилт 7. Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах талаар зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх		-	Хэрэгжилтийн хувь	0	100	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн захиргааны акт 35	
26	Арга хэмжээ 7.1. Захиргааны хэм хэмжээний актын салбарын нэгдсэн бүртгэл хөтлөх цахим системийг бий болгоно	-	Системийн тоо	0	1	Захиргааны хэм хэмжээний актын салбарын нэгдсэн бүртгэл хөтлөх цахим системийг бий болгох бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	10
27	Арга хэмжээ 7.2. Захиргааны хэм хэмжээний актын тоог цөөрүүлэх, журмаар зохицуулах харилцааг холбогдох хуульд тусгах асуудлаар салбарт хамаарах Засгийн газрын тогтоолоор баталсан хэм хэмжээний актад хяналт шинжилгээ, үнэлгээ хийнэ.	-	Хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн актын тоо	0	26	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар 17 хуульд захиргааны хэм хэмжээний акт батлах 35 эрх олгосон заалт туссанаас 26 заалтын хүрээнд захиргааны хэм хэмжээний актыг баталсан байна. Дээрх 35 акт тус бүрд хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах 5 асуудлын хүрээнд хийж байна. 1.тэмдэглэх хэсэгт үндэслэл болгосон хуулиар тусгайлан эрх олгосон хуулийн заалтад өөрчлөлт орсон эсэх; 2.хавсралтаар баталсан журмын дотор үндэслэл болгож эшлэл хийсэн заалтууд болон бусад зохицуулалтууд нь шинээр батлагдсан хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх; 3.бүртгэлтэй шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулсан болон хүчингүй болгосон шийдвэрээ тухай бүрд нь ирүүлж сан холбогдох хөдөлгөөн хийсэн эсэх; 4.ач холбогдлоо алдсан, дагаж мөрдөхгүй болсон шийдвэрийг сангаас хасуулах арга хэмжээ авсан эсэх; 5.улсын нэгдсэн санд бүртгүүлээгүй шийдвэр байгаа эсэх, хуульд нийцүүлэн бүртгүүлэх арга хэмжээг авсан эсэх.	50
Зорилт 8. Олон улсын, бүсийн, гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах, гадаадын хөрөнгө оруулалтыг татахад		-	Хэрэгжилтийн хувь	0	100	Батлагдсан төлөвлөгөө 1 30 арга хэмжээнд яамны 39 албан хаагч	
28	Арга хэмжээ 8.1. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2025 оны гадаад айлчлал, арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, батлуулна.	-	Батлагдсан баримт бичиг	1	1	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2025 оны гадаад айлчлал, арга хэмжээний төлөвлөгөөг 2025 оны 1 дүгээр сард Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Эхний хагас жилийн хэрэгжилтийг удирдлагад тайлагнасан.	100
29	Арга хэмжээ 8.2. Олон улсын байгууллага, гадаад улсын байгууллагатай гэрээ, хэлэлцээр байгуулах ажлыг зохион байгуулах, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлнэ.	-	Бүртгүүлсэн гэрээ хэлэлцээрийн тоо	0	4	Тайлант хугацаанд 5 Харилцан ойлголцлын санамж бичиг, 2 гэрээг айлын талтай эцэслэн тохирч, Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулсан. Мөн нийт 7 гэрээ, санамж бичгийг холбогдох журмын дагуу Гадаад харилцааны яаманд бүртгүүлсэн.	100

30	Арга хэмжээ 8.3. Сайд, Төрийн нарийн бичгийн дарга болон яамны хэмжээнд албан болон ажлын айлчлал, гадаад томилолтыг зохион байгуулна.	-	Оролцсон арга хэмжээний тоо	0	48	1.Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд Ц.Баатархүү Бүгд Найрамдах Казакстан Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс, Бүгд Найрамдах Узбекистан Улсад 2025 оны 01 дүгээр сарын 26-аас 02 дугаар сарын 02-ны өдрүүдэд ажлын айлчлал хийхээр төлөвлөж, ГХЯ болон холбогдох Элчин сайдын яамдтай хамтран уг айлчлалын бэлтгэл ажлыг хангаж, зардлын асуудлыг Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/189 дугаартай тушаалаар албажуулсан боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан цуцлагдсан. 2.Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од Дэлхийн Банкны хэрэгжүүлж буй "Ухаалаг засаг-2" төслийн хүрээнд цахим шилжилт, шинэ өндөр технологи судлах, туршлага солилцох хөтөлбөрт оролцохоор Бүгд Найрамдах Солонгос Улсад 2025 оны 2 дугаар сарын 9-16-ны өдрүүдэд албан томилолтоор ажилласан. 3.Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од АНДСХАБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргыг сонгох тус байгууллагын Онцгой Удирдах зөвлөлийн хуралд 2025 оны 2 дугаар сарын 20-ны өдөр БНХАУ-ын Бээжин хотноо оролцохоор төлөвлөж, Гадаад харилцааны яамнаас холбогдох санал, бүрэн эрхийг авсан боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалж оролцоогүй. 4.ЦХИХХ-ны сайд Ц.Баатархүү Ази, Номхон далайн цахилгаан холбооны байгууллагаас Токио хотноо 2025 оны 5 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд зохион байгуулсан "Ази, Номхон далайн орнуудын мэдээлэл, харилцаа холбооны сайд нарын уулзалт"-д оролцож, Япон Улсад ажлын айлчлал хийхээр төлөвлөн, холбогдох бэлтгэл ажлыг ГХЯ болон Элчин сайдын яамтай хамтран зохион байгуулсан. Мөн сайдын гадаад томилолтын асуудлыг 2025 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулж, удирдамжийг батлуулсан боловч, цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан цуцлагдсан. Тайлант хугацаанд гадаад улс орнуудад зохион байгуулсан 30 арга хэмжээнд яамны 39 албан хаагчийн оролцоход холбогдох дэмжлэгийг үзүүлж ажилласан.	100
31	Арга хэмжээ 8.4. Гадаад улс орнуудад зохион байгуулах харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын үзэсгэлэн, экспод төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудыг оролцуулах ажлыг зохион байгуулна.	-	Арга хэмжээний тоо	0	1	КолПро ХХК, Онлайн Нэтворкс ХХК болон ДДиш ХХК-ийн төлөөлөгчид 2025 оны 3 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд Испанийн Хаант Улсын Барселон хотноо зохион байгуулсан "Дэлхийн үүрэн холбооны конгресс (Mobile World Congress)"-т павильон түрээслэн оролцохоор хүсэлт ирүүлсний дагуу Гадаад харилцааны яаманд хүсэлт хүргүүлж, 8 төлөөлөгчийн визний асуудалд дэмжлэг үзүүлж ажилласан.	100
32	Арга хэмжээ 8.5. Олон улсын, бүсийн, гадаадын байгууллагуудтай хамтран ажиллах, гадаадын хөрөнгө оруулалтыг татах ажил зохион байгуулна.	-	Арга хэмжээний тоо	0	1	Төлөвлөгөөний хүрээнд дараах уулзалт, арга хэмжээг зохион байгуулсан. 1.Монгол Улсын "Хиймэл оюун, их өгөгдлийн үндэсний стратеги" сэдэвт бага хурлыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран зохион байгуулсан ба хуралд 7 гадаадын илтгэгч оролцсон. 2.Тус яамны сайд Ц.Баатархүү Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Нгуен Дуан Танийг 1 дүгээр сарын 08-ны өдөр хүлээн авч харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд хамтран ажиллах талаар санал солилцов. 3.Мөн сайд Ц.Баатархүү 1 дүгээр сарын 15-ны өдөр Бүгд Найрамдах Энэтхэг улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Атул Малхари Готсурвег хүлээн авч Монгол Улсын мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг Энэтхэг Улсад мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх, хоёр улсын мэдээллийн технологийн компаниудын хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр санал солилцов. 4.Тус яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од 2025 оны 2 дугаар сарын 26-ны өдөр Бүгд Найрамдах Франц Улсын Сансрын агентлаг болон Талес компанийн төлөөллийг хүлээн авч Францын сансар судлалын үндэсний төвтэй 2019 онд байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичгийг шинэчлэн байгуулав. 5. Сайд Ц.Баатархүү БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шэнь Миньжуан болон бусад албаны төлөөлөгчдийг 2025 оны 3 дугаар сарын 12-ны өдөр хүлээн авч уулзав. Уулзалтаар талууд хоёр улсын шинжлэх ухаан, мэдээллийн технологийн салбарт хамтын ажиллагааг шинэ шатанд гаргах талаар санал солилцов. Мөн цахим худалдааны талбарт Монгол Улсын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг Alibaba-гаар дамжуулан экспортлох ажлыг эрчимжүүлж, хоёр талын цахим уулзалтыг зохион байгуулах асуудлыг онцлов. 6.Мөн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од БНСУ-ЫН Олон улсын хамтын ажиллагааны байгууллага КОИКА-гийн Монгол Улс дахь Суурин төлөөлөгч Жу Хэйн Наныг 3 дугаар сарын 25-ны өдөр хүлээн авч Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн зорилтын хүрээнд шинэ болон дагуул хотуудад тулгуурлан AI дата төв байгуулах асуудал дээр хамтран ажиллах хүсэлтээ илэрхийлэв. 7.Сайд Ц.Баатархүү Монгол Улс дахь НҮБ-ын Суурин зохицуулагчаар шинээр томилогдсон Якоб ван Хиердэнийг 04 дүгээр сарын 03-ны өдөр хүлээн авч манай зүгээс Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн туршилтын бүсийг Монгол Улсад байгуулах, Төрийн их өгөгдлийн продакшн орчны "DATA LAKE" үүсгэхэд шаардагдах дэд бүтэц болон программ хангамжийн төслийн хүрээнд хамтын ажиллагааг эхлүүлэх хүсэлтийг албан ёсоор хүргүүлэв. 8.Сайд Ц.Баатархүү Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Хунгээв Сүгсавадыг 4 дүгээр сарын 9-ний өдөр хүлээн авч төрийн үйлчилгээг цахимжуулах чиглэлээр санал солилцов.	100

						уулзалтын мөрөөр Монгол Улсын цахим шилжилтийн сайн туршлагыг хуваалцаж, мөн тус улсын холоогдох яамтай Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах хүсэлтээ илэрхийлэв. 9 Сайд Ц Баатархүү Япон Улсаас Монгол Улсад Суугаа Элчин Сайд Игавахака Масарүг 4 дүгээр сарын 22-ны өдөр хүлээн авч уулзав. Уулзалтаар удахгүй болох Японы Эзэн хааны төрийн айлчлалын талаар болон цаашдын хамтын ажиллагааны чиглэлээр санал солилцов. 10 Мөн Төрийн нарийн бичгийн дарга П.Алтан-Од Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банкны Хөрөнгө оруулалт хариуцсан захирал Константин Лимитовский болон бусад албан төлөөллийг 2025 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр хүлээн авч уулзав.	
Яамны стратегийн зорилт 2. Нийтийн мэдээллийн дэд бүтцийг төрөөс иргэдэд үзүүлдэг үйлчилгээг дахин инженерчлэл хийх, төрийн үйлчилгээг түргэн, шуурхай, чирэгдэлгүй хүргэхэд чиглүүлэн хөгжүүлэх							
Зорилт 1. Төрийн байгууллагын үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэх, бизнес процессын дахин инженерчлэл хийх		-	Хэрэгжилтийн хувь	0	100	70	
33	Арга хэмжээ 1.1. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийх, санал, зөвлөмж боловсруулна.	-	Судалгааны тоо-1 Зөвлөмжийн тоо-1	0 0	2 1	Нийтийн мэдээллийн дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдлын судалгаа хийх, санал, зөвлөмж боловсруулах ажлын даалгарыг боловсруулан үнэлгээний хороонд хүргүүлсэн.	30
34	Арга хэмжээ 1.2. Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх аргачлал боловсруулах, эрх зүйн орчныг бий болгоно.	-	Аргачлалын тоо	0	1	Төрийн үйлчилгээнд процессын дахин инженерчлэл хийх аргачлал боловсруулах, эрх зүйн орчныг бий болгохоор судалж байна.	10
35	Арга хэмжээ 1.3. Төрийн байгууллагын үйлчилгээнд процессын дахин инженерчлэл, шинжилгээ хийнэ.	-	Байгууллагын тоо	0	2	Тус яамнаас Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газарт Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацийн зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй "Ухаалаг засаг 2 төсөл"-ийн 2026 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 2.1.11.2-д "Төрийн үйлчилгээний процессын дахин инженерчлэл хийх" төслийн ажлын даалгарыг боловсруулах чиглэлийг хүргүүлсэн. Мөн Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 11 дүгээр сарын А/102 дугаар тушаалаар Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-ээр дамжуулан үзүүлж буй үйлчилгээг иргэдэд шуурхай, чирэгдэлгүй хүргэх, чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор дахин загварчлах, үе шатыг бууруулах талаар санал, зөвлөмж гаргасан.	50
36	Арга хэмжээ 1.4. Төрийн мэдээлэл солилцооны систем (ХҮР)-ийг тархсан бүтцэд шилжүүлнэ.	-	Тархмал бүтцэд шилжсэн мэдээлэл хариуцагч байгууллагын тоо	0	3	"Ухаалаг засаг 2 төсөл"-ийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 2.2.2.2-т заасан "Бие даасан техникийн зөвлөх/ХҮР систем"-ийн зөвлөх сонгон шалгаруулж, 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн №2222 дугаартай гэрээ байгуулагдсан. "Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХҮР)-ийг тархсан бүтцэд шилжүүлэх" зөвлөх үйлчилгээний ажлын явц болон гүйцэтгэгчийн тайланг хянан баталгаажуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн А/188 дугаар тушаалаар байгуулсан. "Төрийн мэдээлэл солилцооны үндсэн систем (ХҮР)-ийг тархсан бүтцэд шилжүүлэх" арга хэмжээг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх техникийн зөвлөх И-Монгол академи УТУГ, Үндэсний дата төв УТУГ-т биечлэн ажиллаж, ажлын даалгарыг боловсронгуй болгох, харьцуулсан судалгааны ажил тус тус хийгдэж байна.	50
37	Арга хэмжээ 1.5. Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт боловсруулна.	-	Хүргүүлсэн дүгнэлт, зөвлөмжийн тоо	0	12	Зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий 2022 оны А/20 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийг цахимаар 2025 оны А/55 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт авах хүсэлтийг isr.gov.mn цахим системээр авч байна. 2025 онд 1 Гадаадын иргэнд оршин суух үнэмлэх хэвлэх киоск машины программ хангамжийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, 2025.01.03-ны өдөр 03/06 бичгээр Гадаадын иргэн, харьяатын газарт; 2.Газрын тосны бүтээгдэхүүн хангамжийн "mpetro.smartsolution" системийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, 2025.02.04-ний өдөр "isr.gov.mn" системээр Ашигт малтмал газрын тосны газарт; 3.Хууль зүйн туслалцааны төвийн химмэл оюунд суурилсан хуулийн зөвлөгөө өгөх мобайл аппликейшн хөгжүүлэх ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжид саналаа 2025.02.17-ны өдөр цахим шуудангаар нэгтгэсэн албан хаагчид; 4.Авто зогсоолын удирдлага, зохион байгуулалтын ухаалаг систем ба тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолттой танилцан, судлан үзэж, зөвлөмж бүхий хариуг 2025.02.18-ны өдөр 03/387 бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газарт; 5.Тээврийн хэрэгслийн нэгдсэн удирдлагын систем (VIMS)-ийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, 2025.02.26-ны өдөр 03/466 бичгээр 2-м тээврийн	100
38	Арга хэмжээ 1.6. "Тусгай дугаар 112"-ын үйл ажиллагаанд шаардлагатай технологийн шийдлийг боловсруулж, нэвтрүүлэх нөхцөлийг судалгаа хийнэ.	-	Судалгааны тоо	0	1	Ажлын даалгарыг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, үнэлгээний хороонд хүргүүлсэн.	30
39	Арга хэмжээ 1.7. Камерын хяналтын нэгдсэн систем бий болгоход шаардлагатай тоног төхөөрөмжийн нөхцөл шаардлагыг тодорхойлох суурь судалгаа хийж стандартын төсөл боловсруулах	-	Судалгааны тоо	0	1	Хууль зүй, дотоод хэргийн яамны 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн "Танилцуулга хүргүүлэх тухай" 7/2857 дугаар албан бичгээр "улсын хэмжээнд нэгдсэн дугаарлалтын систем нэвтрүүлэх, нийслэлд Мэдээлэл, шуурхай удирдлагын төвийн үйл ажиллагааг өргөтгөх, орон нутагт дуудлага хүлээн авах ажиллагааг Телекамерын хяналтын дэд төвтэй уялдуулан зохион байгуулах" ажлын Техник, эдийн засгийн үндэслэл /ГЗЗҮ/ боловсруулахад шаардлагатай системийн шинжилгээ хийлгэх танилцуулга ирүүлсэн. Үүнтэй холбогдуулан холбогдох албан хаагчтай мэдээлэл солилцох зорилго бүхий уулзалтыг цахим хэлбэрээр зохион байгуулсан.	70
40	Арга хэмжээ 1.8. Шил ажиллагааны хүрээнд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг сурталчилна.	-	Арга хэмжээний тоо	0	1	Шил ажиллагааны хүрээнд нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг сурталчлах ажлын даалгарыг боловсруулан Төрийн нарийн бичгийн дарга 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр батлуулсан.	30

41	Арга хэмжээ 1.9. Олон улсын дата төвийн зах зээлийн судалгаа хийж, дата төвийн зах зээлд өрсөлдөх үндэсний стратегийг боловсруулна.	-	Боловсруулсан баримт бичгийн тоо	0	1	"Олон улсын дата төвийн зах зээлийн судалгаа хийж, дата төвийн зах зээлд өрсөлдөх үндэсний стратегийг боловсруулах" арга хэмжээг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөнд тусгаж, судалгааны ажлын даалгаврыг боловсруулан 2025.03.31-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулан тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарласан. Тус тендерт 2 оролцогч материал ирүүлсэн боловч шаардлага хангах тендер ирүүлээгүй тул худалдан авах ажиллагааг дахин зарласан.	30
42	Арга хэмжээ 1.10. Цахим засаглалыг эрчимжүүлж, салбар бүрийн эрх зүйн орчны реформ хийнэ.	-	Боловсруулсан баримт бичгийн тоо	0	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" А/01 дүгээр тушаалын хүрээнд "Цахим засаглалыг эрчимжүүлэх, салбар бүрийн эрх зүйн орчны реформ хийхэд хуулийн зөвлөх үйлчилгээ"-ний ажлын даалгаврыг боловсруулж, 2025.03.31-ний батлуулсан. Мөн Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.14-ний өдрийн А/89 дүгээр тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан бөгөөд Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулагдсан. Тус тендер шалгаруулалтад шаардлагад нийцсэн тендер ирүүлээгүй тул дахин зарлахаар ажиллаж байна.	30
43	Арга хэмжээ 1.11. Цахим шилжилтийг салбар бүрд эрчимжүүлэхэд тухайн салбарын талаарх хөндлөнгийн анализ бүхий материал, нэвтрүүлэг, контент хийнэ.	-	Контентын тоо	0	1	Ажлын даалгаврыг боловсруулж 2025.03.31-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Үйлчилгээ авах тендерийг зохион байгуулах 2025.04.30-ны өдрийн А/124 дугаартай үнэлгээний хорооны тушаалыг батлуулсан. 2025.06.02 өдөр тендерийг нээж үнэлгээ хийсэн. Зөвлөмжийг Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн.	50
Зорилт 2. Цахим засаглалыг хөгжүүлэх, нэвтрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах			-	Хэрэгжилтийн хувь	0	100	80
44	Арга хэмжээ 2.1. "Дижитал-Аймаг, Дижитал-Хот" зөвлөмжийг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллана.	-	Баримт бичгийн тоо Зөвлөмж хэрэгжүүлсэн аймаг, дүүргийн тоо	0 2	1 8	"Цахим аймаг-Дижитал хот" зөвлөмжийг боловсруулан хэрэгжүүлэх ажлын хэсгийн тушаалыг ЦХИХХС-ын 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн А/07 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд тус ажлын хэсэг 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдөр хуралдаж ажлын хэсгийн төлөвлөгөөг баталсан. 2025 онд 7 аймагт "Цахим аймаг-Дижитал хот" зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулахаар худалдан авах ажиллагааны ажлын даалгаврыг боловсруулан 2025.03.31-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулж, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр 2025.05.08-ны өдөр нээлттэй тендер зарлаж, 2025.05.29-ны өдөр тендерийг нээсэн. Тендерийг үнэлэх үйл ажиллагаа явагдаж байна.	100
45	Арга хэмжээ 2.2. Төрийн программ хангамж, мэдээллийн системүүдийн кодын хувилбарыг бүртгэх, хадгалах систем нэвтрүүлнэ. (GITLAB)	-	Нэвтрүүлсэн системийн тоо	0	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" А/01 дүгээр тушаалын хүрээнд "Төрийн программ хангамж, мэдээллийн системүүдийн кодын хувилбар бүртгэх, хадгалах систем нэвтрүүлэх" үйлчилгээний ажлын даалгаврыг төслийг бэлтгэх 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 03/327 албан бичгийг Үндэсний дата төв УТҮГ-т хүргүүлэн хамтран боловсруулж, 03 дугаар сарын 31-ний батлуулсан. Мөн Төрийн нарийн бичгийн даргын 04 дүгээр сарын 14-ний өдрийн А/89 дүгээр тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. 05 дугаар сарын 29-ний өдөр ЦХИХХЯ/20250103050 дугаартай худалдан авах ажиллагааг нээж, зөвлөмж гаргасан.	90
46	Арга хэмжээ 2.3. Шүүхийн салбарын цахим шилжилт төслийг хэрэгжүүлэх суурь судалгаа хийж зөвлөмж боловсруулна.	-	Зөвлөмжийн тоо	0	1	Ажлын даалгаврыг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр батлуулсан. Тайлант хугацаа болоогүй.	30
Зорилт 3. Төрийн цахим үйлчилгээг шуурхай, хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх, нэгдсэн төлөвлөлт хийх, мэргэжил, арга зүй, технологийн шийдэл, удирдлагаар хангах			-	Хэрэгжилтийн хувь	0	100	75
47	Арга хэмжээ 3.1. Төрийн үйлчилгээг хиймэл оюуны тусламжтайгаар хүсэлт шийдвэрлэх чадавх бүхий "Ухаалаг E-Mongolia" системийг хөгжүүлнэ	-	Хөгжүүлж, нэвтрүүлсэн хувилбар	E-Mongolia 4.0	E-Mongolia 5.0	Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр нээлттэй тендер шалгаруулалт зарласан бөгөөд 2 оролцогч санал ирүүлсэн боловч шаардлага хангаагүй тул дахин зарласан. 2025 оны 06 дугаар сарын 17-ны өдөр нээгнэ.	30
48	Арга хэмжээ 3.2. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шаардлагатай системүүдийг хувийн хэвшилд шилжүүлэх ажлыг зохион байгуулах	-	Системийн	0	2	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шаардлагатай системүүдийг хувийн хэвшилд шилжүүлэх ажлыг зохион байгуулахаар судалж байна. Тайлант хугацаа болоогүй.	10
49	Арга хэмжээ 3.3. Блокчейн технологи ашиглан бүртгэлийн үйл ажиллагааг баталгаажуулах ажлыг зохион байгуулна.	-	Блокчейн технологи нэвтрүүлсэн бүртгэлийн үйлчилгээний тоо	0	1	Ажлын даалгаврыг боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргаар 2025 оны 03 дугаар сарын 31-ний өдөр батлуулсан бөгөөд 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн А/96 тушаалаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороо байгуулагдсан. "Блокчейн технологи ашиглан бүртгэлийн үйл ажиллагааг баталгаажуулах" үйлчилгээг Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр зарлан 2025.05.28-ны өдөр нээсэн. Тендерт оролцогчдыг хянан, үнэлэх ажиллагаа явагдаж байна.	90

50	Арга хэмжээ 3.4. Төрийн байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программын нэгж лицензийн үнийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг-Засгийн газарт хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1	Төрийн байгууллагуудын албан хэрэгцээнд ашиглах баримт бичиг боловсруулах программын нэгж лицензийн үнийг бууруулахад чиглэсэн ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах 2025.01.20-ны өдрийн 01/128 албан бичгийг ЗГХЭГ, ШСАА, ТЕГ, ТХААГ, Нийтийн төв, ҮДТ-д хүргүүлсэн. Улмаар ажлын хэсгийг ЦХИХХСайдын 2025.02.12-ны өдрийн А/37 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. Үүнд: Нөхцөл байдлын судалгаа авах талаарх 2025.01.22-ны өдрийн 01/153 тоот бичгийг мэдээлэл хариуцагч 60 гаруй байгууллагад хүргүүлсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 5,671 байгууллагын 17% буюу 939 байгууллага судалгаанд хамрагдсан бөгөөд 49,017 компьютер ашиглаж байгаагийн 88.5% нь, мөн 2,261 сервер ашиглаж байгаагийн 79% нь тус тус Майкрософтын корпорацын бүтээгдэхүүнийг сонгон ашиглаж байна. Түүнчлэн төсвийн 68 байгууллагаас сүүлийн 2 жилийн хугацаанд Майкрософтын 6 төрлийн 138,164 ширхэг лицензийг нийт 5.5 тэрбум төгрөгөөр худалдан авсан байна. Кибер аюулгүй байдлын зөвлөлтэй хамтран Монгол дахь АНУ-ын Элчин сайдын ямаар дамжуулан Майкрософт корпорацын Казахстан, Болгар, Румын, Египет, Турк Улсад байрладаг бүс нутгийг хариуцсан төвүүдийн мэргэжилтнүүдтэй холбогдон ажиллаж, мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангах, бүх өгөгдлийг МУ-ын нутаг дэвсгэр дээр хадгалах шийдэл, оюуны өмчийн зөрчилгүй программ хангамж ашиглах, хамтран ажиллах талаар зөвлөлдсөн. Майкрософт корпорац МУЗГ-ын хэрэгцээ, шаардлагад нийцсэн шийдэл санал болгохоор урьдчилсан байдлаар хүлээн зөвшөөрсөн. Ажлын хэсгийн 2025.05.13-ны өдрийн хурлаар Майкрософт корпорацтай цахим уулзалт хийж, харилцан ойлголцлын санамж бичгийн болон нууцлалын гэрээний төслийг эцэслэн боловсруулсан. Лицензийг нэгдсэн зохион байгуулалттайгаар "Цахим дэлгүүр"-т байршуулахад шаардлагатай техникийн тодорхойлолт хамтран боловсруулах 2025.03.21-ний өдрийн 03/632 албан бичгийг ҮДТ-д хүргүүлэн хамтран ажилласан. Улмаар 2025.05.12-ны өдрийн байдлаар ТХААГ-тай хамтран 12 төрлийн лицензийг ерөнхий гэрээгээр худалдан авах боломжийг бүрдүүлсэн. Явцын тайланг 2025.05.20-ны өдрийн 01/1195 тоот бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж 2025.05.28-ны Инновац, цахим бодлогын байнгын хорооны хурлаар танилцуулгдсан.	90
51	Арга хэмжээ 3.5. Кирилл болон үндэсний бичгийн хооронд харилцан хөрвүүлэг хийх, зөв бичих дүрмийн алдаа хянах программ нэвтрүүлнэ.	-	Нэвтрүүлсэн программын тоо	0	1	Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс баталгаажуулсан "Дуаллайн" ХХК-ийн боловсруулсан "Алдаа шалгагч, бичиг хөрвүүлэгч" программ нь төрийн үйл ажиллагаанд нэвтрүүлэн ашиглахад аюулгүй байдлын хувьд эрсдэлтэй талаар ЗГХЭГ-ын 2025.04.17-ны өдрийн ХЭГ/1043 дугаар албан бичиг (Тагнуулын ерөнхий газрын даргын 2025.04.01-ний өдрийн ЗГХЭГ-ын тэргүүн дэд даргад хүргүүлсэн ТЕГ/01/128 дугаар албан бичиг)-ээр ирсэн тул эрсдэлийг бууруулахад чиглэсэн агуулга бүхий Ажлын даалгаврын төслийг боловсруулан хамтран батлахаар Хэлний бодлогын үндэсний зөвлөлийн Ажлын албанд Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.28-ны өдрийн 02/975 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	60
52	Арга хэмжээ 3.6. Технологийн тэргүүлэх байгууллагын сертификаттай мэргэжилтэн бэлтгэх, шаардлагатай түвшинд шалгалтын дотоод систем нэвтрүүлэх, хүний нөөцийн нэгдсэн бүртгэлийн систем бий болгоно.	-	Системийн тоо	0	1	Уг төлөвлөлтийн тухайд 2025 оны эхний хагас жилийн байдлаар Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" А/01 дүгээр тушаалын хүрээнд "Технологийн тэргүүлэх байгууллагын сертификаттай мэргэжилтэн бэлтгэх, шаардлагатай түвшинд шалгалтын дотоод систем нэвтрүүлэх, хүний нөөцийн нэгдсэн бүртгэлийн систем бий болгох" үйлчилгээний ажлын даалгаварт тусгах санал авах 2025.02.27-ны өдрийн 03/483 албан бичгийг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, харьяа УТҮГ-д хүргүүлж, ирүүлсэн хариуг нэгтгэн боловсруулж, 2025.03.31-ний батлуулсан. Төрийн нарийн бичгийн даргын 2025.04.14-ний өдрийн А/89 дүгээр тушаалаар үнэлгээний хороо байгуулагдсан. 2025.05.29-ний өдөр ЦХИХХЯ/20250103041 дугаартай худалдан авах ажиллагааг нээж, зөвлөмжийг гаргасан. 4 дүгээр улиралд багтаан гүйцэтгэхээр төлөвлөсөн.	90
Зорилт 4. Төрийн байгууллагуудын мэдээллийн сан, мэдээллийн систем, нээлттэй өгөгдлийг уялдуулах, нийтийн түлхүүрийн дэд бүтцийн тогтолцоо, нийтийн мэдээллийн дэд бүтцийг хөгжүүлэх, зохион байгуулах, зохицуулах		-	Хэрэгжилтийн хувь	0	100	87.7	
53	Арга хэмжээ 4.1. Суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн бүртгэл хөтөлнө.	-	Бүртгэсэн мэдээллийн сангийн тоо	0	45	Тайлант хугацаа болоогүй.	-
54	Арга хэмжээ 4.2. Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэнэ.		Их өгөгдлийн (big data) сан үүсгэх гүйцэтгэлийн хувиар	0	10	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024.11.15-ны өдрийн А/51 дугаар тушаалаар Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдаж, удирдамжийн дагуу дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн. Үүнд: -Хүний хувийн мэдээлэлд хамаарах 35 төрлийн мэдээлэл, хуулийн этгээдэд хамаарах 14 төрлийн мэдээллийг тодорхойлох боломжгүй болгох арга, аргачлалын хамт И-Монгол академи УТҮГ-т хүргүүлсэн. -Нийгмийн даатгалын мэдээллийн сан, Нийгмийн халамжийн мэдээллийн сан, Хүн амын өрхийн мэдээллийн сан, Мал тооллогын мэдээллийн сан, Бизнес регистрийн мэдээллийн сангийн мета-өгөгдлийг тус тус мэдээлэл хариуцагчдаас гаргуулан авах, мета-шинжилгээ хийх ажлыг зохион байгуулсан. -Өгөгдлийг 5 төрөл (Hashed keys, Masking, Obfuscation, Generalization, Perturbation)-өөр тодорхойлох боломжгүй болгон хувирах хэрэгсэл, хувиргасан өгөгдлийг нууцлалтайгаар ХҮР системээр дамжуулах сервисийг тус тус хөгжүүлж хөдөлмөр, халамж, статистик, даатгалын мэдээллийн сан хариуцсан 3 байгууллагад туршилтаар суурилуулж, заавар гарын авлагаар хангаж ажилласан. -"И-Монгол академи" УТҮГ-ын төлөөлөлтэй хамтран Үндэсний статистикийн хороо, Нийгмийн даатгалын ерөнхий газрын Мэдээллийн технологийн төв дээр 2025 оны 05 сарын 27-28-ны өдрүүдэд ажиллаж, өгөгдлийг хувирах, нууцлан дамжуулах явцад гарсан эх кодын алдааг засварлах, турших ажлуудыг хийж гүйцэтгэсэн. -Нийтийн мэдээллийн сангийн өгөгдлийг их өгөгдлийн санд нэгтгэх дэд бүтцийг бэлдэх ажлын хүрээнд Үндэсний дата төв дээр 500GB санах ой бүхий нөөцийг үүсгэсэн.	90

55	Арга хэмжээ 4.3. Хүн, хуулийн этгээдийг төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР)-д холбох ажлыг зохион байгуулна.	-	Шинээр холбогдсон хүн, хуулийн этгээдийн тоо	0	55	2025 оны эхний хагас жилийн байдлаар "ХУР" системд төрийн 172, хувийн хэвшлийн 462 байгууллага, нийт 634 байгууллага холбогдсон.	100
56	Арга хэмжээ 4.4. Хүн, хуулийн этгээдийг танилт, нэвтрэлтийн систем (Дан)-д холбох ажлыг зохион байгуулна	-	Шинээр холбогдсон хүн, хуулийн этгээдийн тоо	0	50	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ын дагуу 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн байдлаар Танилт, нэвтрэлтийн нэгдсэн систем (ДАН)-д төрийн 98 байгууллагын 188, хувийн 276 байгууллагын 325 систем бүртгэлтэй 2,220,683 иргэн байна.	100
57	Арга хэмжээ 4.5. Сэлгэн ажиллах /high availability/ дата төвийн тоног төхөөрөмжийн нөөцийг бий болгоно	-	Хэрэгжилтийн хувь	0	100	Үндэсний дата төв УТҮГ-аас Сэлгэн ажиллах нөөц төвд шаардлагатай сервер, сүлжээ, хадгалах төхөөрөмж зэрэг 10 төрлийн 128 ширхэг техник хэрэгслийн тодорхойлолтыг боловсруулсан ирүүлсний дагуу "Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж нийлүүлэх" ЦХИХХЯ/20250102135 дугаар бүхий худалдан авах ажиллагааг зохион байгуулж байна.	70
58	Арга хэмжээ 4.6. Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах төв /11-11/ болон Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээллийн сан, мэдээллийн системийг нэгтгэх асуудлыг судалж, Засгийн газарт хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу Иргэд, олон нийттэй харилцах төв "11-11"-ийн мэдээллийн системийг мэдэгдэл хүргэх системтэй холбож, улмаар иргэдийн ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн шийдвэрлэлтэд мэдэгдэл хүргэдэг болсон. Засгийн газрын "Их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, нэгдсэн мэдээлэл хяналтын систем"-д 11-11, 101, 102, 103, 105 дугааруудад ирүүлсэн дуудлага, түүний төрөл, шийдвэрлэлтийн статистик мэдээллийг "дашбоард" хэлбэрээр харах боломжийг бүрдүүлсэн. - Иргэдийн асуултад хариулах, хууль эрх зүйн зөвлөмж өгөх, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн явцыг мэдээлэх чадвартай хиймэл оюунд суурилсан "IVA" системийг "11-11.mn" веб хуудсанд холбож, "Харилцагчийн үйлчилгээний хиймэл оюуны виртуал ажилтан, операторын үйлчилгээ"-г 2025.03.31-ний өдөр ЗГХЭГ-тай хамтран нэвтрүүлсэн. Тус хиймэл оюун нь 2025.05.29-ны байдлаар 51,099 үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс 13,944 нь өргөдөл, гомдол бүртгэгдсэний 4,791 буюу 34%-ийг хүний оролцоогүй шийдвэрлээд байна. -Засгийн газрын "11-11", нийслэлийн "1800-1200" дугаарын үйл ажиллагаанд ашиглаж буй мэдээллийн сан, системийг нэгтгэх шийдлийг боловсруулж, "API" сервисийн хөгжүүлэлт хийх чиглэлийг 2025 оны 02/1204 бичгээр И-Монгол академид хүргүүлэн, хөгжүүлэлтийн ажлыг эхлүүлсэн. Үүнтэй холбогдуулан ЗГХЭГ, НЗДТГ, Иргэд олон нийттэй харилцах төв, Нийслэлийн нэгдсэн үйлчилгээний төв, И-Монгол академи УТҮГ, ERP систем хөгжүүлэгч байгууллагууд болон тоон гарын үсгийн гэрчилгээжүүлэх байгууллагуудтай нийт 2 удаагийн уулзалтыг зохион байгуулж, ажлын хэсэг байгуулах төслийг ЗГХЭГ-т хүргүүлсэн. ЗГХЭГ-ын Тэргүүн дэд даргын 2025.05.27-ны өдрийн 175 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан, 3 дугаар улиралд багтаан дуусгах үүргийг өгсөн. Мөн Тус "11-11" төвд иргэдийн гадаад улсаас хийх дуудлагыг хүлээх авах боломжийг судалж, холбогдох саналыг 2025 оны 01/613 албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Явцын тайланг 2025.05.20-ны өдрийн 01/1195 тоот бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Улмаар 2025.05.28-ны Инновац, цахим бодлогын байнгын хорооны хурлаар танилцуулагдсан.	100
59	Арга хэмжээ 4.7. Үндэсний программ хангамжийн их дэлгүүр систем (Mindgolia) 2.0 хувилбарыг нэвтрүүлнэ.	-	Нэвтрүүлсэн системийн	0	1	Үндэсний программ хангамжийн их дэлгүүр систем нэвтрүүлэх ажил хүлээгдэж байна.	0
60	Арга хэмжээ 4.8. Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал (opendata.gov.mn)-ийн 3.0 хувилбарыг нэвтрүүлнэ.	-	Нэвтрүүлсэн системийн тоо	0	1	Ажлын даалгаврыг боловсруулан 2025.03.31-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан бөгөөд 2025.04.14-ний өдрийн А/88 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдсан. 2025.05.29-ний өдөр тендерийг нээж, үнэлгээ хийн, зөвлөмжийг Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлээд байна.	70
61	Арга хэмжээ 4.9. "Ухаалаг засаг II" төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.	-	Төсөл, хөтөлбөрийн тоо	10	20	Төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу дараах ажлуудын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд: Баталгаажуулсан 22 гэрээ ба хэрэгжиж байгаа төслүүдийн мэдээлэл. Үүнд: 1. Дижитал шилжилтийн зохицуулагч зөвлөх С.Тэнгис, Дижитал Эдийн засгийн зохицуулагч зөвлөх Б.Тэмүүлэн нарын төслийн гэрээний хэрэгжилт 2025.06.13-ны өдөр дууссан. 2. "Ахмад настай иргэдийн дижитал ур чадварыг дээшлүүлэх" төслийн хүрээнд 4 хувь зөвлөх Х.Саруул, Б.Оюумаа, Б.Энхмөрөн, Б.Оюунцэцэг, ман нээлтийн үйл ажиллагаа, гарын авлага боловсруулах төсөл /Очирпресс ХХК/ 2025.03.30-ны өдөр бүрэн хэрэгжиж дууссан. 3. Сангийн яамны Төрийн худалдан авах ажиллагаатай холбоотой дүрэм, журам, удирдамж, баримт бичгийг боловсруулах 3 зөвлөх /Б.Мөнхцэцэг, Д.Номингэрэл нарын гэрээ хэрэгжиж байна. Б.Энхжаргалын гэрээ 2025.04.14нд дууссан. 4. Төрийн худалдан авах ажиллагааны газрын Цахим худалдан авах ажиллагааны системд дэмжлэг үзүүлэх хувь зөвлөхийн Х.Хангайтэй хийсэн гэрээ хэрэгжиж байна. 5. Эдийн засаг, хөгжлийн яамны Цахим зөвшөөрлийн системийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх бие даасан зөвлөх /Б.Цогбаярын гэрээ хэрэгжиж байна. Азбилэг, Сарангэрэл, Амармөрөн 2025.01.21-02.25-ны өдрүүд хэрэгжиж дууссан. 6. ТХН-ийн санхүүгийн программ Инфо систем ХХК хэрэгжиж байна. 7. ТХН-ийн оффиссын программ Могул ХХК хэрэгжиж байна. АТГ-ын "Мэдүүлгийн бүрдүүлэлтийн систем II үе шат төсөл"-ийн гэрээ /Ай Ти Зон ХХК/ хэрэгжиж байна. 8. ҮДТ-ийн "Монголын интернэтийн харилцан холболтын төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах төслийн гэрээ /Мобинет ХХК/ хэрэгжиж байна. 9. Цахим шилжилтийн талаар хууль, тогтоомжийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулах төслийн гэрээ /Эм эн агентлаг/ хэрэгжиж байна. 10. Цахим шилжилт хийхэд шаардлагатай дүрэм журмуудын хийдэл, зөрчлийг тогтоож, санал боловсруулах төслийн гэрээ /Ай ти инсайт/ хэрэгжиж байна. 11. Хур/техникийн зөвлөх төслийн гэрээ /Магсаржав/ хэрэгжиж байна. Гэрээний төслийг боловсруулж буй 2 төслийн мэдээлэл. Үүнд: 1. Дижитал эдийн засгийн зохицуулагч зөвлөх А.Анарын төслийн гэрээний төсөл боловсруулж байна. 2. Үүлэн	100

Зорилт 1. Нийгэм, эдийн засгийг инновац шингэсэн технологиор хөгжүүлэх, инновац шингэсэн технологиудыг нутагшуулах, турших, инновацын бодлогын хэрэгжилтийг зохицуулах		-	Төслийн тоо Грант олгосон төслийн тоо Арга хэмжээний тоо Судалгааны тоо	0	3	Судалгааны тоо 1 Хүргүүлсэн баримт бичгийн тоо 1 Боловсруулсан баримт бичгийн тоо 1 Тавигдах шаардлагын тоо 0 Арга хэмжээний тоо 3 Сургалтын тоо 1 Гарын авлагын тоо 0 Нэр томьёоны лавлахын тоо 1 Хөтөлбөрийн тоо 0	
72	Арга хэмжээ 1.1. "Шинэ Хархорум" хотод "Орхоны хөндий"-д өндөр технологи, инновац, бизнес хөгжлийн төв байгуулах судалгаа хийнэ.	-	Боловсруулсан баримт бичгийн тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй.	-
73	Арга хэмжээ 1.2. Инновацын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийнэ.	-	Судалгааны тоо	0	1	"Инновацын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх" ажлын даалгаврыг боловсруулан баталгаажуулсан. Тус ажлыг Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэнгээс хийж гүйцэтгэн үнэлгээний тайланг 2025 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Инновац, цахим бодлогын байнгын хороонд хүргүүлсэн.	100
74	Арга хэмжээ 1.3. Инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг шинэчлэн боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй.	0
75	Арга хэмжээ 1.4. Инновац, мэдээллийн технологийн паркийн талаар судалгаа хийж, цаашид баримтлах бодлогыг боловсруулж, бүс, орон нутагт парк байгуулахад тавигдах шаардлагыг тодорхойлно.	-	Бодлогын баримт бичгийн тоо Тавигдах шаардлагын тоо	0 0	1 1	Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд бүс орон нутагт өндөр технологи, инновацыг нэвтрүүлнэ зорилтын хүрээнд "Мэдээллийн технологийн төрөлжсөн хаб/хамтын оффис байгуулах ТЭЗҮ, зураг төслийн ажил хийж гүйцэтгэх" ажлын хүрээнд мэдээллийн технологийн хаб/хамтын оффисыг бүс болгонд байгуулахтай холбоотой судалгааны эхлэлийн тайланг хүлээн авч танилцсан. Судалгаанд үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/80 дугаар тушаалаар уг хабуудыг байгуулах бүсийн байршилг тогтоосон. Дээрх тогтоосон байршлуудыг Засаг дарга нартай холбогдон ажиллаж, хаб байгуулах нөхцөл шаардлага, эсхиз зургийг боловсруулж байна.	90
76	Арга хэмжээ 1.5. Инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын болон тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн төслийн тоо	0	1	"Инновацын төслийг улсын төсвөөс санхүүжүүлэх, инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам"-ыг шинэчлэн боловсруулж, 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 01/832 дугаартай албан бичгээр Засгийн газрын гишүүд, нийслэлийн Засаг дарга нараас санал авч, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2025 оны 05 дүгээр сарын 01-ний өдрийн 01/1029 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Тус тогтоолын төсөл нь Засгийн газрын 2025 оны 05 дүгээр сарын 07-ны өдрийн 224 дүгээр тогтоолоор батлагдсан.	100
77	Арга хэмжээ 1.6. "ICT экспло 2025" арга хэмжээг зохион байгуулна.	-	Арга хэмжээний тоо	0	1	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд сурталчлан таниулах, төрийн болон салбарын хувийн хэвшлийн байгууллагуудын дунд салбар хэлэлцүүлэг, "ICT EXPO-2025" үзэсгэлэнг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн А/38 дугаар тушаалаар байгуулсан бөгөөд уг ажлын хурлаар тус арга хэмжээг 2025 оны 09 дүгээр сард зохион байгуулахаар төлөвлөсөн. Үүний дагуу тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн "ICT ЭКСПО 2025" ЦХИХХЯ/20250103113 дугаартай арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/113 дугаар тушаалаар байгуулж, тендер шалгаруулалтыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулан 06 дугаар сарын 03-ны өдөр тендерийг нээгээд байна.	80
78	Арга хэмжээ 1.7. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж буй дрон жолоодлогын Улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулна.	-	Арга хэмжээний тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй. Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан "Дрон жолоодлогын улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах" ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан.	30
79	Арга хэмжээ 1.8. Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ний сургалт зохион байгуулна.	-	Сургалтын тоо	0	1	"Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн сургалт зохион байгуулах" ЦХИХХЯ/20250603127 дугаартай үйлчилгээний гэрээ байгуулах эрх олгох, зардал гаргах тухай 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/37 дугаар тушаалын дагуу 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр "Дижиталсервис" ХХК-тай Г/04 дугаартай гэрээг байгуулан 2025 оны 02 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд сургалтыг амжилттай зохион байгуулсан. Тус сургалт нь дроны талаарх онолын мэдлэг, техникийн дадлага гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдсэн бөгөөд дроны бүтэц, нислэгийн үндсэн зарчим, аюулгүй ажиллагааны дүрэм гэсэн сэдвүүдээр нийт 8 цагийн сургалтыг Хонхорын радио нэвтрүүлэх төв станцын байршилд хийсэн. Сургалтад оролцогчид нислэгийн дадлага хийж, автомат болон гараар удирдах техникийг туршин үзсэн бөгөөд анхан шатны оролцогчид дрон хөөргөх, буулгах, энгийн зураг авахад харин дунд шатны оролцогчид илүү нарийн маршрутын дагуу бартаат нислэг үйлдэж, салхины нөхцөлд тэнцвэр хадгалах, тусгай зорилгоор бичлэг хийх зэрэг чадварыг эзэмшүүлсэн.	100
80	Арга хэмжээ 1.9. Дрон жолоодлогын сургалт хөтөлбөр боловсруулах, шалгалт баталгаажуулалтын гарын авлага боловсруулна.	-	Гарын авлагын тоо	0	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны А/47 дугаар тушаалаар "Сургалтын тогтолцоо бий болгох, зэрэг дэв олгох, санал боловсруулах" үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, эхний хурлыг 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр цахимаар зохион байгуулсан. Уг хурлаар "Дроны жолоодлогын сургалт хөтөлбөр боловсруулах, шалгалт баталгаажуулалтын гарын авлага боловсруулах" ажлын даалгаврын төслийг танилцуулан тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан. Уг ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог тус яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/98 дугаар тушаалаар байгуулсан. Уг тендерийг 2025 оны 04 дүгээр сарын 22-ны зарласан боловч амжилтгүй болсон тул дахин 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр зарлан үнэлж, МУИС-ийн Бизнесийн сургуультай 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр гэрээг байгуулсан.	90

81	Арга хэмжээ 1.10. Дэвшилтэт Технологийн нэр томьёоны лавлах гаргана.	-	Нэр томьёоны лавлахын тоо	0	1	Дэвшилтэт технологийн нэр томьёоны лавлах гаргах ажлыг "Системийн инженерчлэлийн институт" ГҮТББ-тай 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Y/14 дүгээр гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.	100
82	Арга хэмжээ 1.11. Монгол улсын инновацын тогтолцооны гүйцэтгэлийг үнэлэх олон улсын судалгааны аргачлалыг нутагшуулж, мэдээллийн технологийн болон өндөр технологийн салбарт инновацын судалгаа хийнэ.	-	Судалгааны тоо	0	1	"Монгол Улсын инновацын тогтолцооны гүйцэтгэлийг үнэлэх олон улсын судалгааны аргачлалыг нутагшуулж, мэдээллийн технологийн болон өндөр технологийн салбарт инновацын судалгаа хийх" ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан. Уг ажлын төндөр шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/133 дугаар тушаалаар байгуулсан.	60
83	Арга хэмжээ 1.12. Шилдэг инновацын төсөл шалгаруулах хөтөлбөрийг орон даяар зохион байгуулна.	-	Арга хэмжээний тоо	0	1	"Инновацын төслийг улсын төсөөс санхүүжүүлэх журам"-ын 3.5-д заасан "Инновацын бүтээгдэхүүний талаар дүгнэлт гаргах, мэргэжлийн шинжээчдийн ажиллах журам"-ын төслийг боловсруулсан. Журмын төсөл хянуулах шатандаа явж байна. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 224 дүгээр тогтоолоор батлагдсан "Инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1-т заасны дагуу инновацын үйл ажиллагаанд оролцогчид грант олгох сонгон шалгаруулалт зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг, ажлын хэсгийн удирдамжийг боловсруулан Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн тушаалаар батлуулсан.	80
84	Арга хэмжээ 1.13. Электроник, автоматжуулалтын салбарын бодлогын судалгаа хийх, стратеги боловсруулна.	-	Боловсруулсан баримт бичгийн тоо	0	1	"Электроникс, автоматжуулалтын салбарын бодлогын судалгаа хийх, стратеги боловсруулах" ЦХИХХЯ/20250603079 дугаартай үйлчилгээний шууд худалдан авалтын ажлыг зохион байгуулж, 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/132 дугаар тушаалаар 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр "Хүрээ санал шийдэл" ХХК-тай байгуулсан Y/13 дугаартай гэрээний дагуу ажлын явцын тайланг хүлээн авсан. Энэхүү тайлан нь Монгол Улсын электроникийн салбарыг хөгжүүлэх нарийвчилсан замын зургийг 2025-2030 он хүртэл тодорхойлж, одоогийн сорилтуудыг шийдвэрлэх, стратегийн боломжуудыг ашиглах замаар эдийн засаг, технологи, нийгмийн хөгжилд томоохон ахиц авчирна. Хэрэв амжилттай хэрэгжвэл Монгол Улс дэлхийн электроникийн зах зээлд тогтвортой байр суурь эзэлж, технологийн тэргүүлэгч орнуудын нэг болох боломжтой.	70
85	Арга хэмжээ 1.14. Инновацыг шинэ санааг хөгжүүлэх бүх насны иргэдэд зориулсан 10 цуврал контент хийнэ.	-	Боловсруулсан баримт бичгийн тоо	0	1	"Инновацлаг санааг хөгжүүлэх бүх насны иргэдэд зориулсан 10 цуврал бичлэг, нэвтрүүлэг, материал бүтээх" ЦХИХХЯ/20250103089 дугаартай төндөр шалгаруулалтыг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн А/112 дугаар тушаалаар байгуулагдсан Үнэлгээний хорооноос 05 дугаар сарын 05-ны өдөр цахим системд нийтлэн зарласан. Төндөрийг 05 дугаар сарын 26-ны өдөр нээхэд оролцогчгүй байсан тул 05 дугаар сарын 29-ний өдөр дахин зарлаж, 06 дугаар сарын 19-ний өдөр нээж, үнэлнэ.	70
86	Арга хэмжээ 1.15. Салбарын мэргэшсэн мэргэжилтнүүдийг практик мэдлэг мэдээллийг оюутнуудад заах боломжийг бүрдүүлж цагийн багш хөтөлбөр боловсруулах, судалгаа хийнэ.	-	Судалгааны тоо	0	1	"Салбарын мэргэшсэн мэргэжилтнүүдийг практик мэдлэг мэдээллийг оюутнуудад заах боломжийг бүрдүүлж цагийн багш хөтөлбөр боловсруулах, судалгаа хийх" ЦХИХХЯ/20250203090 үйлчилгээний төндөр шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/139 дугаар тушаалаар байгуулсан. Тус үнэлгээний хороо төндөр шалгаруулалтыг зохион байгуулж, хамгийн сайн төндөр ирүүлсэн "Дийг Ай Ти" ХХК-д гэрээ байгуулах мэдэгдлийг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр хүргүүлж, 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр гэрээ байгуулан төлөвлөгөөт хуваарийн дагуу ажиллаж байна.	70
87	Арга хэмжээ 1.16. Салбарын судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээг хангах, тэдний чанарыг сайжруулах зорилгоор цалинтай PhD доктор хөтөлбөрийг боловсруулна.	-	Хэрэгжүүлсэн хөтөлбөрийн тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй.	0
88	Арга хэмжээ 1.17. Мэдээллийн технологийн ажилтан, албан хаагчдын мэдлэг, мэдээллээ солилцох, шинэ технологи, инновацтай танилцах боломжийг олгосон Мэдээллийн технологийн ажилтны өдөрлөгийг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан өдөрлөгийн тоо	0	1	Тус арга хэмжээг 2025 оны 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн. Хугацаа болоогүй.	-
89	Арга хэмжээ 1.18. "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны хөгжил-2025" бүсийн зөвлөгөөн зохион байгуулна.	-	Арга хэмжээний тоо	0	1	Зүүн бүсийн цахим шилжилтийг эрчимжүүлэх, бүс нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, орон нутгийн мэдээллийн технологийн салбарыг хөгжүүлэх, эдийн засаг, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхэд цахим технологийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох, зүүн бүс нутагт ажиллаж байгаа салбарын мэргэжилтэн, албан хаагчдын санал санаачилгыг дэмжих, санал хүсэлтийг бодлого, арга хэмжээнд тусган ажиллах зорилгоор "Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын зүүн бүсийн чуулга уулзалт"-ыг Хэнтий аймгийн төв Чингис хотод 2025 оны 03 дугаар сарын 29-ний өдөр зохион байгуулсан. Чуулганаар зүүн бүсэд тулгарч буй нийгмийн асуудлыг дижитал технологи нэвтрүүлэн шийдвэрлэх, орон нутгийн бизнест дижитал шийдлийг нэвтрүүлэх, орон нутгийн гарааны бизнесийг хөгжүүлэх зэрэг асуудлаар форум хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн чуулганы үеэр "Мэдээллийн технологийн төрөлжсөн төв байгуулах", "Зүүн бүсийн логистикийн төв байгуулах" санамж бичгүүд зурагдаж, зүүн бүсийн 45 суманд төрийн үйлчилгээний КИОСК машиныг гардуулах, Хиймэл Оюуны илч "1000 AI Ambassador" хөтөлбөрийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулсан.	100
90	Арга хэмжээ 1.19. Бүсчилсэн хөгжлийн цахим сургалт хэлэлцүүлэг зохион байгуулна.	-	Зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо	0	1	"Бүсчилсэн хөгжлийн цахим сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах" ЦХИХХЯ/20250603124 дугаартай үйлчилгээний гэрээ байгуулах эрх олгох, зардал гаргах тухай 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/53 дугаар тушаалын дагуу "Норт шүр" ХХК-тай 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Y/02 дугаартай гэрээ байгуулсан. Арга хэмжээний хөтөлбөрийн дагуу 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр 4 сэдвийн хүрээнд сургалт хийгдсэн бөгөөд 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдөр 3 сэдвийн хүрээнд сургалт явуулсны дараа хэлэлцүүлгийг танхимаар 250, цахимаар 200 гаруй оролцогчдын дунд зохион байгуулж, санал солилцсон.	100

91	Арга хэмжээ 1.20. Мэдээлэл технологийн Улсын олимпиад зохион байгуулна.	-	Зохион байгуулсан Улсын олимпиадын тоо	0	1	Тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн "Мэдээллийн технологийн улсын олимпиад зохион байгуулах" ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан. Ажлын даалгаврын дагуу шууд худалдан авалтын хэлбэрээр гүйцэтгэгчийг сонгож, холбогдох тушаал болон гэрээг батлуулан гэрээний дагуу 2025 оны 04 дүгээр сарын 25-наас 27-ны өдрүүдэд уг олимпиадыг амжилттай зохион байгуулахад оролцож, гэрээ дүнгээ актыг баталгаажуулан холбогдох санхүүжилт олгогдсон. Мэдээллийн технологийн улсын олимпиад (Улсын программчлалын 33 дугаар олимпиад)-ыг 2025 оны 04 дүгээр сарын 25-наас 27-ны өдрүүдэд Монгол Улсын Боловсролын их сургуульд зохион байгуулсан. Уг олимпиадад нийт 7 сургуулийн 11 багийн 33 оюутан оролцон 2 өдрийн турш 6 бодлогыг шийдвэрлэх программ бичиж өрсөлдөж, онооны эрэмбээр алтан медаль 1, мөнгөн медаль 2, хүрэл медаль 3, шагналт тусгай байр 2, шагналт байр 3-ыг тус тус шалгаруулсан.	100
Зорилт 2. Хиймэл оюун ухаан, их өгөгдөл зэрэг дэвшилтэт технологид тулгуурлан нийгэм, эдийн засгийн хөгжлийг хурдасгах, хиймэл оюун ухаанд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэхэд салбар хоорондын уялдааг хангах		-	Төслийн тоо Нэвтрүүлсэн үйлчилгээний тоо Хүргүүлсэн баримт бичиг	0	2 2 1	Судалгааны тоо 1	
92	Арга хэмжээ 2.1. Хиймэл оюун, их өгөгдөл, блокчэйн, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндбоксын журмыг Засгийн газарт хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн журмын тоо	0	1	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 6.1.6-д заасны дагуу "Хиймэл оюун, их өгөгдөл, блокчэйн, сансрын үйлдвэрлэлийн дэвшилтэт технологид суурилсан сэндбокс орчны зохицуулалтын журам"-ын төслийг эхний байдлаар боловсруулсан. Төлөвлөгөөт хугацаанд багтаан батлуулахаар ажиллаж байна.	60
93	Арга хэмжээ 2.2. Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн төсөл боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1	Их өгөгдөл, хиймэл оюуны өнөөгийн нөхцөл байдал болон дэлхийн цаашдын чиг хандлагын талаар судалж, 2025 оны 01 дүгээр сарын 17-ноос 02 дугаар сарын 05-ны өдрүүдэд төр, хувийн хэвшлийн байгууллага, банк, финтек, шинжлэх ухааны салбарын эрдэмтэн, судлаачид, үүрэн холбооны оператор болон их, дээд сургуулийн нийт 500 орчим төлөөлөлтэй 6 удаагийн уулзалтуудыг зохион байгуулж, гарсан санал, зөвлөмжийг нэгтгэн дүн шинжилгээ хийсний дүнд уг стратегийн төслийн эхний хувилбарыг боловсруулсан. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн төслийг хэрэгжүүлнэ.	80
94	Арга хэмжээ 2.3. Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулна.	-	Арга хэмжээний тоо	0	1	Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/172 дугаар тушаалаар байгуулагдсан Хиймэл оюун ухааны стратеги төлөвлөгөө боловсруулах, олон улсын дээд хэмжээний арга хэмжээ зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн хурлыг 2025 оны 1 дүгээр сарын 22, 27, 02 дугаар сарын 05, 10, 11-ний өдрүүдэд зохион байгуулсан. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратегийн төслийг хэлэлцүүлэх анхдугаар чуулганыг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулсан. Уг чуулганд гадаадын болон дотоодын илтгэгч, панелист, төр, хувийн хэвшлийн 1000 орчим төлөөлөл оролцож, их өгөгдөл, хиймэл оюуны чиглэлийн өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэлэлцсэн. Тус яамнаас 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 02/1117 дугаартай албан бичгээр их дээд сургууль, Шинжлэх ухааны академи, Монголын санхүүгийн технологийн холбоо ГҮТББ, Монголын банкны холбоо ГҮТББ, Үүрэн холбооны оператор компаниудад хэлэлцүүлэгт урьж, 05 дугаар сарын 19-ний өдөр "Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги"-ийн төслийг эцэслэх цуврал хэлэлцүүлгийн эхний хэлэлцүүлгийг ШУА-ийн эрдэмтэн, их дээд сургуулийн багш, судлаач нарт, хоёрдугаар хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр арилжааны банк, финтекийн холбооны гишүүд, үүрэн холбооны оператор компаниудад, 3 дахь хэлэлцүүлгийг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр стартап компаниудын дунд зохион байгуулсан. Төслийг сайд Ц.Баатархүү, Инновац, бодлого зохицуулалтын газрын дарга Д.Мөнхбат нар танилцуулан хэлэлцүүлж, оролцогчдын асуултад хариулж, санал солилцсон.	100
95	Арга хэмжээ 2.4. Их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай систем, техник хэрэгсэл, хүний нөөцийн тооцоо, судалгаа хийнэ.	-	Судалгааны тоо	0	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/51 дүгээр тушаалаар их өгөгдлийн сан үүсгэн бүрдүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, хэрэгжилтийг ханган ажилласан. Үүний үр дүнд нийгмийн даатгалын мэдээллийн сан, нийгмийн халамжийн мэдээллийн сан, хүн амын өрхийн мэдээллийн сан, мал тооллогын мэдээллийн сан, бизнес регистрийн мэдээллийн сан зэрэг 5 өгөгдлийн сангийн мета өгөгдөлд боловсруулалт хийсэн. Мэдээллийн сан тус бүрээс 1 сая гаруй өгөгдлийн регистрийн дугаарыг шифрлэлтийн арга ашиглан татан авч, тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн. "Хиймэл оюун ухааны засаглалыг бий болгох судалгаа боловсруулах, төр болон хувийн хэвшилд шат дараалалтай нэвтрүүлэхэд замын зураглал боловсруулах" ЦХИХХЯ/20250203067 дугаартай үйлчилгээний тендер шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/83 дугаар тушаалаар байгуулсан. Тус үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг зохион байгуулж, хамгийн сайн тендер ирүүлсэн "Дижитал воркс" ХХК-ийг шалгаруулан мэдэгдэл хүргүүлж, гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч компани явцын болон эцсийн тайлангаа ирүүлж, гэрээний хугацаанд багтааж, сайжруулалт хийж гэрээг ажиллаж байна.	100
96	Арга хэмжээ 2.5. Хиймэл оюуны засаглалыг бий болгох судалгаа боловсруулах, төр болон хувийн хэвшилд шат дараалалтай нэвтрүүлэхэд замын зураглал боловсруулна.	-	Баримт бичгийн тоо	0	1	Тус яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн. "Хиймэл оюун ухааны засаглалыг бий болгох судалгаа боловсруулах, төр болон хувийн хэвшилд шат дараалалтай нэвтрүүлэхэд замын зураглал боловсруулах" ЦХИХХЯ/20250203067 дугаартай үйлчилгээний тендер шалгаруулах үүрэг бүхий Үнэлгээний хороог Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/83 дугаар тушаалаар байгуулсан. Тус үнэлгээний хороо тендер шалгаруулалтыг зохион байгуулж, хамгийн сайн тендер ирүүлсэн "Дижитал воркс" ХХК-ийг шалгаруулан мэдэгдэл хүргүүлж, гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч компани явцын болон эцсийн тайлангаа ирүүлж, гэрээний хугацаанд багтааж, сайжруулалт хийж гэрээг ажиллаж байна.	90
97	Арга хэмжээ 2.6. Хиймэл оюунд суурилсан "Виртуал багш" системийг хөгжүүлнэ.	-	Системийн тоо	0	1	Тайлант хугацаа болоогүй.	0
98	Арга хэмжээ 2.7. Хиймэл оюуны хөгжүүлэлтийн төв байгуулах ажлын даалгавар боловсруулна.	-	Баримт бичгийн тоо	0	1	"Хиймэл оюун ухааны хөгжүүлэлтийн төв байгуулах ажлын даалгавар боловсруулах" ажлын даалгаврын дагуу "Эй ай ризирч" ХХК-тай 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Y/03 дугаартай гэрээг байгуулж, тайланг авсан. Тайлангийн хүрээнд уг төв нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого болох "Алсын хараа 2050"-ын зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэсэн стратегийн ач холбогдол бүхий санаачилга бөгөөд энэхүү төв нь шинжлэх ухаан, технологи, инновацын тогтолцоог бэхжүүлж, эдийн засгийн төрөлжилтийг дэмжих, нийгмийн хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, олон улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чухал хувь нэмэр оруулах боломжтой. Мөн стратегийн ач холбогдол, эдийн засгийн боломжууд, нийгмийн үр ашиг, технологийн чадавхын хөгжил, сорилт бэрхшээл, олон улсын хамтын ажиллагаа, урт хугацааны өгөөж зэргийг боловсруулан гаргаж өгснөөс гадна зөвлөмж хэсэгт 6 шийдэл бөгөөд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг гаргасан байна.	100

99	Арга хэмжээ 2.8. Өгөгдлийн хакатон зохион байгуулна.	-	Зохион байгуулсан хакатоны тоо	0	1	Өгөгдлийн хакатон зохион байгуулах бэлтгэл ажил хангагдсан. 3 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.	50
100	Арга хэмжээ 2.9. Хиймэл оюуны Улсын олимпиад зохион байгуулна.	-	Зохион Улсын олимпиадын тоо	0	1	"Хиймэл оюуны Улсын олимпиад зохион байгуулах" ЦХИХХЯ/20250603108 дугаартай үйлчилгээний Y11 дугаартай гэрээг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Монгол Улсын Их Сургуулийн Мэдээллийн Технологи, Электроникийн сургуультай байгуулсан. Уг гэрээний хүрээнд www.kaggle.com платформыг ашиглан олимпиадыг хоёр үе шаттайгаар зохион байгуулсан бөгөөд нэгдүгээр шатыг 2025 оны 05 дугаар сарын 02-14-ний хооронд цахимаар, хоёрдугаар шатыг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр танхимаар тус тус явуулсан. Уг олимпиадад нийслэл, орон нутгаас нийт 272 сурагч бүртгүүлэн оролцсоноос нэгдүгээр шатанд 91, хоёрдугаар шатанд 50 сурагч тус тус хамрагдсан. Хоёрдугаар шатнаас шалгарсан 8 сурагч Хиймэл оюуны олон улсын II олимпиадад Монгол Улсаа төлөөлөн оролцохоор тодорсон.	100
Зорилт 3. Мэдээллийн технологи, программ хангамжийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, гарааны бизнесийг дэмжих		-	ТЭЗҮ тоо Төлөвлөгөөний тоо Арга хэмжээний тоо Үйлчилгээний тоо Байгууллагын тоо	0	1 1 1 1 5	Хүргүүлсэн журмын төслийн тоо 2	
101	Арга хэмжээ 3.1. Инновац, өндөр технологи, гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын санг байгуулах судалгаа хийх, экосистемийн замын зураглал боловсруулна.	-	Судалгааны тоо Зураглалын төслийн тоо	0	1 1	"Инновац, өндөр технологи, гарааны бизнесийг дэмжих хөрөнгө оруулалтын санг байгуулах судалгаа хийх, экосистемийн замын зураглал боловсруулах" ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан. Уг ажлын төндөр шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/133 дугаар тушаалаар байгуулсан.	60
102	Арга хэмжээ 3.2. "Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх, виртуал бүсийн ажиллах журам"-ын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн журмын төслийн тоо	0	1	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 11.7-д заасны дагуу "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажиллах журам"-ын төслийг боловсруулан Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх Үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралд танилцуулан хэлэлцүүлсэн бөгөөд хурлын шийдвэрээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтсон. Уг шийдвэрийн дагуу журмын төслийг Засгийн газрын тогтоолын төсөл, журмын танилцуулгын хамт боловсруулж, ЗГХЭГ, Шадар сайд нар, Засгийн газрын гишүүд болон Үндэсний хороод зэрэг нийт 22 байгууллагад 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1009 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үүний дагуу 19 байгууллагаас ирсэн саналыг нэгтгэн журмын төслийг эцэслэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	100
103	Арга хэмжээ 3.3. "Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам"-ын төслийг боловсруулж, Засгийн газарт хүргүүлнэ.	-	Хүргүүлсэн журмын төслийн тоо	0	1	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 13.4-т заасны дагуу "Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам"-ын төслийг боловсруулан, Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх Үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн хуралд танилцуулан хэлэлцүүлсэн бөгөөд хурлын шийдвэрээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тогтсон. Дээрх шийдвэрийн дагуу журмын төслийг Засгийн газрын тогтоолын төсөл, журмын танилцуулгын хамт боловсруулж, ЗГХЭГ, Шадар сайд нар, Засгийн газрын гишүүд болон Үндэсний хороод зэрэг нийт 22 байгууллагад 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1009 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үүний дагуу 19 байгууллагаас ирсэн саналыг нэгтгэн журмын төслийг эцэслэж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	100
104	Арга хэмжээ 3.4. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн платформ хөгжүүлнэ.	-	Платформын тоо	0	1	Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан "Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн платформ" хөгжүүлэх" ажлын даалгаврыг боловсруулан батлуулсан. Уг ажлын төндөр шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/190 дүгээр тушаалаар байгуулагдан 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдөр зарлахаар ажиллаж байна.	60
105	Арга хэмжээ 3.5. Дроны туршилтын төв байгуулах ажлыг эхлүүлнэ.	-	Хэрэгжилтийн хувь	0	100	Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн ерөнхий газраас 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдөр 1/381 албан бичгээр ирүүлсэн байршлуудыг 2025 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр 02/851 албан бичгээр Харилцаа холбооны зохицуулах хороонд радио давтамжийн харилцан нөлөөллийн хэмжилт дүгнэлт гаргуулахаар хүргүүлсний дагуу дүгнэлт хэмжилтийн тайлан хүлээн авсан. Тус байршлууд нь газарзүй дэд бүтцийг судлахад Баянзүрх дүүргийн байршил нь намагтай, дэд бүтцээс 5км зайтай, харин Дархан-Уул аймгийн байршил нь Атарын 4 дүгээр аяны талбайтай давхцуулж, түр хугацаанд ашиглах байршил гэдэг утгаар өгсөн нь уг туршилтын бүс байгуулахад шаардлага хангахгүй тул нарийвчилсан шаардлагыг боловсруулан 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр 02/239 дугаартай албан бичгийг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн. Үүний дагуу дээрх байгууллагаас урьдчилсан байдлаар 4 байршлуудын мэдээллийг авч, Иргэний нисэхийн ерөнхий газраас урьдчилсан дүгнэлт гаргуулан боломжит байршлуудыг албажуулж, авахаар ГЗБГЗЗБГ-аас 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдөр 1/1672 албан бичиг хүргүүлсэн. Мөн РТУС-ний Хонхор дахь станцын талбайд нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн түр туршилтын бүс байгуулахаар холбогдох зөвшөөрлүүдийг Иргэний нисэхийн ерөнхий газраас 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр 01/849 албан бичгээр авч, Зэвсэгт хүчний жанжин штабын харьяа Агаарын цэргийн командлалаас зөвшилцөхөөр албан бичиг хүргүүлсэн. Мөн Хот байгуулалт, хотын стандартын газраас ирүүлсэн 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр 02/80 албан бичгээр Архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг батлуулах шаардлагын дагуу холбогдох материалыг бүрдүүлэн ажиллаж байна.	80

106	Арга хэмжээ 3.6. МХХТ-ийн салбарын бизнес эрхлэгч, гарааны бизнесүүдэд ээлтэй, хууль, эрхзүй, санхүүгийн тогтвортой орчныг бүрдүүлэх "Business friendly Mongolia" хөтөлбөр боловсруулна.	-	Хөтөлбөрийн тоо	0	1	"МХХТ-ийн салбарын бизнес эрхлэгч, гарааны бизнесүүдэд ээлтэй, хууль, эрхзүй, санхүүгийн тогтвортой орчныг бүрдүүлэх "Business friendly Mongolia" хөтөлбөр боловсруулна. Уг ажлын тендер шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий Үнэлгээний хороог тус яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/159 дүгээр тушаалаар байгуулсан.	60
171	Арга хэмжээ 4.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх, тайлагнах, гүйцэтгэлийг хянаж, санхүүжилтийн эрх нээлгэх, санхүүжилтийг олгоно.	-	Батлагдсан төсөл, арга хэмжээ, төлөвлөгөөний тоо	11	11	ЦХИХХС-ын Улсын төсвийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/02, төсөл, арга хэмжээний багцад задлах шийдвэрийг А/01, эрх шилжүүлэлтийг А/03 дугаар тушаалаар тус тус баталсан. ЦХИХХС-ын багцын улсын төсвийн хөрөнгө оруулалтын мэдээг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 03/326 дугаартай албан бичгээр, 2024 онд ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 03/132 дугаартай албан бичгээр тус тус Сангийн яаманд хүргүүлсэн. -ЦХИХХС-ын багцын хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлын төсөвт 35.7 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. 2025 оны 2 дугаар улирлын байдлаар улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл гараагүй. МУЗГ-ын 233 дугаар тогтоолоор ТХААГ-т худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар шийдвэрлэсний дагуу 3 төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолтыг батлуулж, хүргүүлсэн. -Улсын төсвийн хөрөнгө оруулалтын УТ2506700069 дугаартай Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ 8.4 тэрбум төгрөгийн төсөл 2025 оны 05 дугаар сарын 31-ний өдөр гэрээ байгуулагдсан. -Монгол Улсын төсвийн хөрөнгөөр Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар болон Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын багцад 2020-2022 онд хэрэгжсэн 5 төсөл, арга хэмжээний чанарын баталгаат болон зүгшрүүлэх тохируулах хугацаанд гүйцэтгэчийн хүлээсэн үүргийн биелэлт хангагдсан тул нийт 5 гэрээт ажлын чанарын баталгаанд байршуулсан 82,647,924 төгрөгийг яамны барьцаа хөрөнгийн 100900067350 тоот дансанд санхүүжилтийн эрх нээх хүсэлтийг 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/161 дугаартай албан бичгээр Сангийн яамны Төрийн сангийн газарт хүргүүлж, санхүүжилтийн эрх нээлгэж гүйцэтгэгчид олгосон.	100
172	Арга хэмжээ 4.3. Төсвийн шууд захирагчийн 2025 оны худалдан авах ажиллагааг төлөвлөж, 2024 оны худалдан авах ажиллагааг тайлагнана.	-	Батлагдсан төлөвлөгөөний тоо, тайлангийн тоо	2	2	Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалаар Яамны 2025 оны урсгал төсвийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулан Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-д нийтэлсэн. Яамны урсгал зардалд нийтдээ 22 төсөл, арга хэмжээ, Цахим шилжилт арга хэмжээнд 60 арга хэмжээ, Инновац, өндөр технологид 18 арга хэмжээ төлөвлөгдсөн. Үүнээс шууд худалдан авалт 45, нээлттэй тендер шалгаруулалт 24, харьцуулалтын аргаар 30, нэг эх үүсвэрээс худалдан авалт 1 байна. Тендер шалгаруулалт 70 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
Зорилт 5. Салбарын нягтлан бодох бүртгэл, тайлагналын нэгдсэн зохицуулалтыг хангах, хэрэгжилтийг хангана.		-	Тайлангийн тоо	5	5	2	
173	Арга хэмжээ 5.1. Төсвийн шууд захирагчийн 2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланг гаргаж Төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгүүлнэ.	-	Тайлангийн тоо	3	3	2024 оны Хөрөнгө оруулалтын санхүүгийн тайлан. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу иж бүрэн бэлтгэж, мөн хуулийн 8.9.1-т заасны дагуу 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 03/185 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлж, ТЭЗ-ын тайланд нэгтгүүлсэн. Мөн Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 24.1-т заасны дагуу ТЭЗ-ийн харьяа БНҮҮС, ӨНХС-ийн санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 01/414 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн аудитын төлөвлөгөөг албажуулан Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. -Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2024 оны санхүүгийн тайланд өгсөн аудитын албан шаардлагын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 02/913 дугаартай албан бичгийг Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.-2025 оны эхний хагас жилийн тайлангийн хуулийн хугацаа болоогүй.	100
174	Арга хэмжээ 5.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллагуудын 2024 оны жилийн эцэс, 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг гаргаж, Сангийн яам, Үндэсний аудитын газарт хүргүүлнэ.	-	Тайлангийн тоо	2	2	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа төсөвт 7, төрийн өмчит 5 байгууллагын 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, холбогдох хоорондын тооцоо, дансны дүн мэдээг тулган баталгаажуулсан. Шууд захирагчдын Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг Төсвийн ерөнхийлөн захирагчийн Санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэн бэлтгэж, 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр Үндэсний аудитын газарт хүргүүлж, хуулийн хугацаанд аудитаар баталгаажуулан тайлагнасан. Санхүүгийн нэгтгэсэн 2024 оны тайланг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/875 дугаартай албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн.	100

175	Арга хэмжээ 5.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг аудитаар баталгаажуулан, Засгийн газрын нэгтгэсэн тайланд нэгтгүүлнэ.	-	Тайлангийн тоо	1	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын 2024 оны Санхүүгийн нэгтгэсэн тайланг Монгол Улсын Засгийн газрын нэгтгэсэн тайланд нэгтгүүлэхээр 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/958 дугаартай албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн. Тайлант онд ТЭЗ-ийн нэгтгэсэн тайланд харьяа төсөвт, төрийн өмчит байгууллагын нийт авлага 27.02 тэрбум төгрөг, богино хугацаат өр төлбөр 35.7 тэрбум төгрөг, 105.6 тэрбум төгрөгийн орлого хүлээн зөвшөөрч, үндсэн үйл ажиллагаа болон нийт /урсгал, хөрөнгийн/ зардалд 96.1 тэрбум төгрөг зарцуулж, нийт балансын хөрөнгө 512.8 тэрбум төгрөг, хуримтлагдсан үр дүн 41.7 тэрбум төгрөгөөр тайлагнасан болно. Мөн ТЭЗ-ын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 01/1291 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хүргүүлсэн.	100
Яамны стратегийн зорилт 7. Хөгжлийн бодлогын баримт бичиг, салбарын стратегийн төлөвлөгөө, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг хангуулах, хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж өгөх							
Зорилт 1. Яам, сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт шалгалт, дотоод аудит явуулах, үр дүнд үнэлгээ хийх;		-	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	0	1	2	
176	Арга хэмжээ 1.1. Яам болон сайдын эрхлэх асуудлын хүрээний төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, төсвийн хөрөнгө, орлого, зарлага, төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад хяналт шалгалт, дотоод аудит явуулах, үр дүнд үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар зөвлөмж гаргах.	-	Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд хяналт шалгалт хийсэн тоо	2	1	Монголын цахилгаан холбоо ХК-д 2024 оны А/59 дүгээр тушаалын дагуу ажлын хэсэг байгуулагдаж 2024 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийж 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрөөр гарсан дүгнэлт зөвлөмжийг хүргүүлж ажилласан. Харьяа болон салбарын нийт 7 байгууллагын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт зөвлөмжийг удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн 1 дүгээр улирлын байдлаар тайланг байгууллага тус бүрд хүргүүлсэн.	100
177	Арга хэмжээ 1.2. Улсын төсөв, гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, хамтран ажиллах гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх зөвлөмж бүхий тайлан гаргах.	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт зөвлөмж бүхий тайлангийн тоо	0	1	Тус яамнаас гадаадын зээл тусламж, гадны хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрөөр хэрэгжүүлж буй Ухаалаг засаг 2 төслийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайлан дүгнэлт зөвлөмжийг Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/520 дугаартай албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.	100
Зорилт 2. Салбарын хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлагаар хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар зөвлөмж гаргах, салбарын төвлөрсөн бус статистик мэдээллийг эрхлэн хөтлөх;		-	Гарсан тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1	2	
178	Арга хэмжээ 2.1. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, стратеги төлөвлөгөө болон сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төлөвлөгөөнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зөвлөмж бүхий тайлан гаргах, аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх дүгнэлт зөвлөмж гаргах	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт зөвлөмж бүхий тайлангийн тоо	0	30	Яам болон харьяа, салбар байгууллын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийж, удирдлагын зөвлөлд танилцуулсан. Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний Стратеги төлөвлөгөөний 2022-2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хуулийн хугацаанд хүргүүлсэн. Мөн Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын төлөвлөлтийн хувьд өмнөх оны жилийн эцсийн хэрэгжилтийн тайланг хагас жилээр тайлагнаж, хагас жилийн гүйцэтгэлийг оны эцсээр тайлагнадаг болно.	100
179	Арга хэмжээ 2.2. Хөндлөнгийн байгууллагын хяналт, шалгалтад хамрагдах	-	Гаргасан тайлбар, баримтын тоо	0	4	"Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө"-ний биелэлт, Улсын хөрөнгө оруулалтын биелэлт, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийн биелэлтэд хамааралтай нэмэлт судалгаа, тайлбар баримтуудын хамтаар 2025 оны 01 дүгээр сарын 16-23-ны өдөр Үндэсний аудитын газарт хүргүүлэн ажилласан.	100
Зорилт 3. Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтийг хангасан эсэхэд хяналт тавих, төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчид тайлагнах;		-	Гарсан тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн баримт бичгийн тоо	0	1	6	

180	Арга хэмжээ 3.1. Хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, удирдлагын зөвлөлийн хурлаар оруулах, зөвлөмж гаргах, зөвлөмжийн биелэлтийг хангасан эсэхэд хяналт тавих, төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн шууд захирагчид тайлагна	-	Удирдлагын зөвлөлийн хурлын тэмдэглэлийн тоо Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн дүгнэлт зөвлөмж бүхий тайлангийн тоо	5 12	3 6	Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт туссан 3 зорилт 6 арга хэмжээг нягтлан үзэж, цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн 2024 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд ерөнхий гүйцэтгэл 96.67 хувьтай гэж дүгнэж, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 03/1396 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Дүгнэлт, зөвлөмж бүхий тайланг үнэлгээний нэгдсэн системд 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөр баталгаажуулсан. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах үндсэн арга хэмжээний биелэлтэд эцсийн хяналт шинжилгээ үнэлгээ хийж, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт 2024 оны 12 сарын 31-ний өдрийн 03/1400 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Мөн Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн эхний удаагийн хэрэгжилтийг Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын monitoring@ags.gov.mn хаягт албаны хаягаар 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр илгээсэн. Цахим системд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш 4 удаа цахим системд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн тайланг оруулсан. Мөн Засгийн газрын 2025 он 43 дугаар тогтоолоор уг тайланг улиралд 1 удаа цахим системээр тайлагнах эрх зүйн зохицуулалттай болсон. Түүнчлэн хагас бүтэн жилээр тайланг цаасан хэлбэрээр илгээхээр байна. Өөрөөр хэлбэл журмын дагуу жилд 4 удаа тайлагнахаар болсон.	100
Яамны стратегийн зорилт 8. Эрсдэлд суурилсан салбарын хяналт шалгалтыг хэрэгжүүлэх замаар хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандартын хэрэгжилт, харилцаа холбоо, мэдээллийн технологийн ашиглалт, үйлчилгээний тасралтгүй, хэвийн найдвартай ажиллагааг хангуулах							
Зорилт 1. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтын бодлогыг тодорхойлох, төлөвлөх, тайлагнах, хэрэгжилтийг хангуулах, эрсдэлийн шинжилгээ хийх, эрсдэлийг бууруулах, үнэлэлт дүгнэлт өгч, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт шалгалтын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг хөтлөх;		-	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэл /хувь/ Албан шаардлагын хэрэгжилтийн /хувь/ Хууль сахин мөрдөлтийн хувь	0 28% 77.3%	100% 27% 79%	27%	
181	Арга хэмжээ 1.1. Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 171 объектод төлөвлөгөөт шалгалт хийнэ	-	Шалгалт хийсэн объектын гүйцэтгэлийн хувь Албан шаардлагын хэрэгжилтийн хувь Хууль сахин мөрдөлтийн хувь	0 85 77.3	100 87 79	Монгол улсын Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дүгээр тогтоолоор баталсан Салбарын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөг үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын 2024 оны А/63 дугаар тушаалаар 2025 оны хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалтын дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 09-00/03 дугаартай удирдамжийн хүрээнд нийт 171 объект төлөвлөснөөс 48 объектод төлөвлөгөөт шалгалт хийсэн. Төлөвлөгөөт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн 159 заалттай 32 албан шаардлага, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	50
182	Арга хэмжээ 1.2. Мэдээлэл харилцаа холбооны салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулна	-	Боловсруулсан баримт бичгийн тоо	0	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-д тусгагдсан ЦХИХХЯ/20250603027 дугаартай "Мэдээлэл харилцаа холбооны салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулах" ажлын даалгавар боловсруулж, Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/191 дүгээр "Гэрээ байгуулах эрх олгох, зардал гаргах тухай" тушаал боловсруулж батлуулсан. "Квантум солюшн" ХХК-тай гэрээ байгуулсан.	70
Зорилт 2. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт шалгалт хийх, холбогдох арга хэмжээг авах;		-	Зөрчил арилгалтын хувь	74 0	79 50	70	
183	Арга хэмжээ 2.1. Гадаадын зээл тусламж, төсөл, хөтөлбөр, улс, орон нутгийн төсөв, бусад хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа харилцаа холбооны барилга байгууламж, шугам сүлжээний зураг төсөл, угсралтын ажлын чанар, техникийн аюулгүй байдлыг хангуулах, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх шалгалт хийнэ.	-	Зөрчил арилгалтын хувь	74	79	1. Монгол улсын Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дүгээр тогтоолоор баталсан Салбарын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөг үндэслэн Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайдын "2025 оны хяналт шалгалтад хамрагдах объектын жагсаалт батлах тухай" 2024 оны А/63 дугаар тушаалын дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 09-00/04 дугаартай удирдамжийн хүрээнд 29 объектод урьдчилан сэргийлэх шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах 80 заалттай 17 албан шаардлага хүргүүлж, 3 аж ахуйн нэгжид 1,800,000 төгрөгийн торгуулийн арга авч, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 2.Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 09-00/06 дугаартай урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 10-18-ны өдрүүдэд Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын Сэлэнгэ баг, Чандмань-Өндөр сумын Улаан асга баг, Эрдэнэбулган сум, Түнэл сум зэрэг газарт баригдсан үүрэн холбооны дахин дамжуулах станцын байр, харилцаа холбооны цахиаг, тоног төхөөрөмжийн зураг төсөл, угсралтын байдалд үзлэг шалгалтыг хийж, гүйцэтгэн холбогдох зураг төсөл, стандарт норм дагуу хийж гүйцэтгэх талаар нийт 6 хугацаатай үүрэг даалгаврыг өгч ажилласан. 3.Харилцаа холбооны барилга байгууламж, шугам сүлжээний тасралтгүй найдвартай ажиллагааг хангуулах, болзошгүй байгалийн гамшигт үзэгдэл, гэмтэл, саатал, ослоос урьдчилан сэргийлэх, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудын аюулгүй байдал, ашиглалт үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангуулах зорилгоор харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудад 09-00-02/001/01 дугаар улсын ахлах байцаагчийн зөвлөмж гаргаж хүргүүлсэн.	100

184	Арга хэмжээ 2.2. Нийслэл, 21 аймгийн теле хяналтын системийн тоног төхөөрөмж, шугам сүлжээний зураг төсөл, угсралт, ашиглалтын байдалд урьдчилан сэргийлэх шалгалт хийнэ.	-	Зөрчил арилгалтын хувь	0	50	Монгол Улсын Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан Салбарын хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 09-00/05 дугаартай удирдамжийн хүрээнд 13 объектод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж 35 заалттай 13 албан шаардлага, 64 заалттай 24 зөвлөмж хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.	100
Зорилт 3. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын хууль тогтоомж, техникийн зохицуулалт, норм стандартын хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэлт дүгнэлт өгөх;		19.8 Урсгал зардал	Албан шаардлагын биелэлтийн хувь	-	1	Хугацаа болоогүй Сургалт 1	
185	Арга хэмжээ 3.1. Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийнэ.	-	Албан шаардлагын биелэлтийн хувь	71	72	2025 оны төлөвлөгөөт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хянах зорилгоор гүйцэтгэлийн шалгалт хийнэ. 2025 оны төлөвлөгөөт шалгалт хийгдэж байна. Гүйцэтгэлийн шалгалт хийгдэх хугацаа болоогүй.	-
186	Арга хэмжээ 3.2. Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч нарын сургалт зохион байгуулна	19.8 Урсгал зардал	Сургалтад хамрагдсан Улсын байцаагчийн тоо	0	1	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 01 дүгээр сарын 02 өдрийн А/01 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө"-д тусгагдсан ЦХИХХЯ/20250603025 дугаар Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын улсын байцаагч нарын сургалт зохион байгуулах А/80 дугаар тушаалаар сургалтын арга хэмжээг зохион байгуулсан. Аймгийн Засаг даргын тамгын газар, Нийслэлийн хяналт шалгалтын газар, Харилцаа холбооны зохицуулах хороо, Зэвсэгт хүчний жанжин штабын Мэдээлэл, харилцаа холбооны хяналтын 31 улсын (ахлах) байцаагчдад 2025 оны 04 дүгээр сарын 23, 24, 25-ны өдөр Улаанбаатар хотод зохион байгууллаа. Сургалтаар хяналт шалгалтын арга хэлбэрийг илүү боловсронгуй болгох, хяналт шалгалтаас иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад учруулж буй бэрхшээл, хүндрэлийг хөнгөвчлөх, хяналт шалгалтын давхардлыг арилгах, соён гэгээрүүлэх үйл ажиллагаа явуулах, аливаа аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг сайжруулан иргэд, аж ахуйн нэгжүүдийн талархлыг хүлээсэн шинэчлэлт, өөрчлөлтийг хийж ажиллахыг улсын (ахлах) байцаагчдад чиглэл болголоо. Сургалтын арга хэмжээг "Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны салбарын хяналт, шалгалтын бодлого, чиглэл, хууль тогтоомж, анхаарах асуудал", "Хиймэл оюун ухааныг салбарын хяналт шалгалтад үр дүнтэй ашиглах, хувь хүний хөгжлийн багц сургалт" гэсэн 2 үндсэн бүлэг сэдвийн хүрээнд зохион байгуулсан ба энэ хүрээнд оролцогч байгууллагууд болох нийслэлийн Прокурорын газар, Авлигатай тэмцэх газрын холбогдох албан тушаалтнууд, Хяналт, үнэлгээний үндэсний хороо, Монгол Улсын Их Сургууль, Мэдээлэл холбооны технологийн сургууль, Монголын үндэсний их сургууль, "Глобал талант менежмент" сургалтын байгууллагын сургагч багш нар хөтөлбөрийн дагуу илтгэл танилцуулга хийж, мэдээлэл солилцон мэдээлэл, харилцаа холбооны салбарт тулгамдаж буй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцүүлэг өрнүүллээ.	100

**ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН ТАЙЛАН**

2025 оны 07 сарын 08-ны өдөр

№

Улаанбаатар хот

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО,
ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 186 арга хэмжээний 2025 оны эхний хагас жилийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийг тавьсан зорилт, хүрэх түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ыг удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын 2.4-т заасан урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээ тус бүрээр үнэлгээ хийж, үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 186 арга хэмжээний биелэлтийг 2025 оны эхний хагас жилийн байдлаар яамны газар, хэлтэс тус бүр хариуцсан ажил үүрэг, чиглэлийн дагуу тайлагнаж, түүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Нийт арга хэмжээнээс эхний хагас жилийн байдлаар биелэлт гараагүй буюу 1-4 дүгээр улиралд төлөвлөсөн зарим арга хэмжээг 0 хувиар үнэлгээ хийсэн бөгөөд нийт 13 арга хэмжээ байна. Мөн хэрэгжилт суурь шатнаас багахан ахицтай буюу дөнгөж эхлүүлсэн гэж үзсэн 3 арга хэмжээг 10 хувиар, 1 арга хэмжээг 20 хувиар, 20 арга хэмжээг 30 хувиар үнэлгээ хийлээ.

Түүнчлэн тухайн арга хэмжээний явцыг журмын дагуу үнэлгээ хийхэд 50 хувиар үнэлгээ хийгдсэн 10 арга хэмжээ, 60 хувиар үнэлгээ хийгдсэн 12 арга хэмжээ, 70 хувиар үнэлгээ хийгдсэн 18 арга хэмжээ, 80 хувиар үнэлгээ хийгдсэн 6 арга хэмжээ, 90 хувиар үнэлгээ хийгдсэн 15 арга хэмжээ, 100 хувиар үнэлгээ хийгдсэн 69 арга хэмжээ байна.

Түүнчлэн дээрх арга хэмжээний үнэлгээнд оруулан тооцоогүй буюу тайлант хугацаа болоогүй 2025 оны 3 дугаар улиралд эхлүүлэх 19 арга хэмжээ байна.

Дээр дурдсан 186 арга хэмжээний 19 арга хэмжээг үнэлгээнээс хасаж тооцсон бөгөөд үлдэх 167 арга хэмжээний гүйцэтгэлийн үнэлгээг арифметик дунджаар тооцож үзэхэд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар 71.01 хувьтай буюу "хангалттай" үнэлэгдсэн болно.

Тодруулбал байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 186 арга хэмжээ төлөвлөсөн байх ба хугацааг төлөвлөхдөө 1-4 дүгээр улиралд хийж дуусгахаар тооцсон байгаагаас эхний хагас жилийн байдлаар нийт арга хэмжээний дийлэнх хувийг эхлүүлсэн байна гэж үзлээ.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнгээс үзэхэд 80-100 хувийн хэрэгжилттэй буюу хэрэгжилт хангалттай, ахицтай дүгнэгдсэн 90 арга хэмжээ байгаа нь нийт үнэлгээ хийсэн 167 арга хэмжээний 53.9 хувийг эзэлж байна. Эдгээрээс зарим хэрэгжилтийг дурдвал:

1. Төрийн байгууллагын зөвшөөрөл олгох үйл ажиллагааг үе шаттайгаар цахимжуулах төлөвлөгөөний хэрэгжилтийг дараах байдлаар тайлагнасан байна. Үүнд:

Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэхтэй холбоотой өнөөгийн нөхцөл байдлын талаар танилцуулга, Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Цахим засаглалын хэлтсийн дарга Б.Билэгдэмбэрэлтэй хамтран боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн ээлжит хуралдаанд танилцуулсан ба Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэлээр “Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хөнгөвчлөх, цахим хэлбэрт шилжүүлэх, холбогдох захиргааны хэм хэмжээний актуудыг хуульд нийцүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Засгийн газрын холбогдох гишүүд, албан тушаалтанд үүрэг даалгавар өгөгдсөн. Зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлснээр 2025 оны 2 дугаар улирлын байдлаар “license.mn”-ээр 76, “e-business.mn”-ээр 44, эрх бүхий байгууллага өөрийн системээр 123, уламжлалт буюу цаасан хэлбэрээр 16 тусгай зөвшөөрлийг олгож, зөвшөөрлийн нэгдсэн санд 151746 нэгж зөвшөөрлийн мэдээлэл бүртгэгдээд байна гэжээ.

2. Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулж батлах ажлыг дараах байдлаар тайлагнасан байна. Үүнд:

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн баримт бичиг болон урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан Засгийн газрын 2020 оны 100 дугаар тогтоолоор баталсан Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлалын дагуу “Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө”-ний анхны төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авч нэгтгэн 5 зорилтын хүрээнд 37 ажил, арга хэмжээ хэрэгжүүлэх стратегийн төслийг, стратегийн зорилтын шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, суурь болон зорилтот түшингийн хамт эцэслэн боловсруулж, Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх үндэсний зөвлөлийн 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн 03 дугаар тогтоолоор “Мэдээллийн технологийн үйлдвэрлэл, дэвшилтэт технологийг хөгжүүлэх стратеги” төлөвлөгөө батлагдсан гэжээ.

3. Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт боловсруулах ажил амжилттай хэрэгжиж байна. Үүнд:

Зөвлөмж, дүгнэлт гаргах үүрэг бүхий 2022 оны А/25 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсгийг ЦХИХХС-ын 2025 оны А/55 дугаар тушаалаар шинэчлэн байгуулсан. Нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө зөвлөмж, дүгнэлт авах хүсэлтийг isr.gov.mn цахим системээр авч байна. 2025 онд:

- Гадаадын иргэнд оршин суух үнэмлэх хэвлэх киоск машины программ хангамжийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, 2025.01.03-ны өдөр 03/06 бичгээр Гадаадын иргэн, харьяатын газарт;

- Газрын тосны бүтээгдэхүүн хангамжийн “mpetro.smartsolution” системийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, 2025.02.04-ний өдөр “isr.gov.mn” системээр Ашигт малтмал газрын тосны газарт;

- Хууль зүйн туслалцааны төвийн хиймэл оюунд суурилсан хуулийн зөвлөгөө өгөх мобайл аппликэйшн хөгжүүлэх ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжид саналаа 2025.02.17-ны өдөр цахим шуудангаар нэгтгэсэн албан хаагчид;

- Авто зогсоолын удирдлага, зохион байгуулалтын ухаалаг систем ба тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолттой танилцан, судлан үзэж, зөвлөмж бүхий хариуг 2025.02.18-ны өдөр 03/387 бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газарт;

- Тээврийн хэрэгслийн нэгдсэн удирдлагын систем (VIMS)-ийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжийг боловсруулж, 2025.02.26-ны өдөр 03/466 бичгээр Зам тээврийн яаманд;

➤ Хүн амын өрхийн мэдээллийн сангийн мэдээллийн системийн /шинэчлэл/ ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжид саналаа өгч, 2025.02.28-ны өдөр "isr.gov.mn" системээр Үндэсний статистикийн хороонд;

➤ Хоригдогсдын бүртгэл, хяналтын системийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжид саналаа өгч, 2025.05.16-ны өдөр "isr.gov.mn" системээр Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт;

➤ Түрээсийн орон сууцны цахим системийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжид саналаа өгч, 2025.05.17-ны өдөр "isr.gov.mn" системээр Төрийн орон сууцны корпорац ХХК-д;

➤ Агуулахын бүртгэлийн системийн ажлын даалгаварт өгөх дүгнэлт, зөвлөмжид саналаа өгч, 2025.05.17-ны өдөр "isr.gov.mn" системээр Зоонозын өвчин судлалын үндэсний төвд тус тус хүргүүлсэн гэж тайлагнажээ.

Мөн Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ний сургалт зохион байгуулах төлөвлөлтийг дараах байдлаар тайлагнасан байна. Үүнд:

"Нисгэгчгүй нисэх төхөөрөмж (дрон)-ийн сургалт зохион байгуулах" ЦХИХХЯ/20250603127 дугаартай үйлчилгээний гэрээ байгуулах эрх олгох, зардал гаргах тухай 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/37 дугаар тушаалын дагуу 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр "Дижиталсервис" ХХК-тай Г/04 дугаартай гэрээг байгуулан 2025 оны 02 дугаар сарын 22-23-ны өдрүүдэд сургалтыг амжилттай зохион байгуулсан.

Тус сургалт нь дроны талаарх онолын мэдлэг, техникийн бэлтгэл, нислэгийн дадлага гэсэн үндсэн гурван хэсгээс бүрдсэн бөгөөд дроны бүтэц, нислэгийн үндсэн зарчим, аюулгүй ажиллагааны дүрэм гэсэн сэдвүүдээр нийт 8 цагийн сургалтыг Хонхорын радио нэвтрүүлэх төв станцын байршилд хийсэн.

Сургалтад оролцогчид нислэгийн дадлага хийж, автомат болон гараар удирдах техникийг туршин үзсэн бөгөөд анхан шатны оролцогчид дрон хөөргөх, буулгах, энгийн зураг авахад харин дунд шатны оролцогчид илүү нарийн маршрутын дагуу бартаат нислэг үйлдэж, салхины нөхцөлд тэнцвэр хадгалах, тусгай зорилгоор бичлэг хийх зэрэг чадварыг эзэмшүүлсэн гэжээ.

Дээрх төлөвлөлтүүдээс гадна "Мэдээлэл технологийн Улсын олимпиад зохион байгуулах" төлөвлөгөөний биелэлт амжилттай хэрэгжсэн байна.

Тодруулбал яамны урсгал зардлын хөрөнгөөр 2025 онд худалдан авахаар төлөвлөсөн "Мэдээллийн технологийн улсын олимпиад зохион байгуулах" ажлын даалгаврыг батлуулж шууд худалдан авалтын хэлбэрээр гүйцэтгэгчийг сонгож, холбогдох тушаал болон гэрээг батлуулан гэрээний дагуу 2025 оны 04 дүгээр сарын 25-наас 27-ны өдрүүдэд олимпиадыг амжилттай зохион байгуулсан.

Уг олимпиад (Улсын программчлалын 33 дугаар олимпиад)-ыг 2025 оны 04 дүгээр сарын 25-наас 27-ны өдрүүдэд Монгол Улсын Боловсролын их сургуульд зохион байгуулан нийт 7 сургуулийн 11 багийн 33 оюутан оролцон 2 өдрийн турш 6 бодлогыг шийдвэрлэх программ бичиж өрсөлдөн онооны эрэмбээр алтан медаль 1, мөнгөн медаль 2, хүрэл медаль 3, шагналт тусгай байр 2, шагналт байр 3-ыг тус тус шалгаруулсан гэжээ.

Мөн дээрх төлөвлөлттэй ижил буюу хиймэл оюуны улсын олимпиад зохион байгуулах ажлын тухайд "Хиймэл оюуны Улсын олимпиад зохион байгуулах" ЦХИХХЯ/20250603108 дугаартай үйлчилгээний Y/11 дугаартай гэрээг 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Монгол Улсын Их Сургуулийн Мэдээллийн Технологи, Электроникийн сургуультай байгуулсан.

Гэрээний хүрээнд www.kaggle.com платформыг ашиглан олимпиадыг хоёр үе шаттайгаар зохион байгуулсан ба нэгдүгээр шатыг 2025 оны 05 дугаар сарын 02-14-ний хооронд цахимаар, хоёрдугаар шатыг 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр танхимаар зохион байгуулсан. Олимпиадад нийслэл, орон нутгаас нийт 272 сурагч бүртгүүлэн оролцсоноос нэгдүгээр шатанд 91, хоёрдугаар шатанд 50 сурагч тус тус хамрагдсан. Хоёрдугаар шатнаас шалгарсан 8 сурагч "Хиймэл оюуны Олон Улсын II олимпиад"-д Монгол Улсаа төлөөлөн оролцохоор тодорсон гэжээ.

Нийт 167 арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг ангилан үзвэл, 0–30 хувийн хэрэгжилттэй буюу эхний шатандаа хэрэгжиж буй 24 арга хэмжээ байгаа нь нийт арга хэмжээний 14.4%-ийг эзэлж байна. Мөн 50–70 хувийн хэрэгжилттэй, дунд шатандаа хэрэгжиж буй 40 арга хэмжээ нь нийт арга хэмжээний 23.9%-ийг бүрдүүлж байна.

Түүнчлэн 1–4 дүгээр улиралд хэрэгжихээр төлөвлөгдсөн боловч тайлант хугацаанд хэрэгжилт хараахан гараагүй 13 арга хэмжээ байгаа нь нийт арга хэмжээний 7.8%-ийг эзэлж байна.

Иймээс хэрэгжилт хангалтгүй, үр дүнг сайжруулах, эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй буюу гүйцэтгэлгүй 0 хувиар үнэлсэн 13 арга хэмжээнээс 11 арга хэмжээг 1–4 дүгээр улиралд төлөвлөсөн боловч биелэлтийг “тайлант хугацаа болоогүй” гэж ирүүлсэн бөгөөд үлдэх 2 арга хэмжээг дараах байдлаар тайлагнасан байна. Үүнд:

Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгуулах төсөл арга хэмжээний тооцоолол хийж, Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэх төлөвлөгөөний биелэлтийг “Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын “Аргачлал, заавар батлах тухай” 2025 оны А/08 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах цаглавар”-ын дагуу тус ажил 06 дугаар сарын 15-ны өдрөөс хэрэгжиж эхэлнэ. Мөн Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд хэрэгжих 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулна” гэсэн шаардлагыг хангах төсөл байхгүй байна” гэж тайлагнажээ.

Мөн “Үндэсний программ хангамжийн их дэлгүүр систем (Mindgolia) 2.0 хувилбарыг нэвтрүүлнэ” гэсэн төлөвлөгөөний биелэлтийг “Үндэсний программ хангамжийн их дэлгүүр систем нэвтрүүлэх ажил хүлээгдэж байна гэж тайлагнасан байх тул 0 хувиар үнэлгээг хийлээ.

ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ДҮГНЭЛТ

Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийх явцад төлөвлөлттэй холбоотой хэд хэдэн асуудал байна гэж үзлээ. Тодруулбал байгууллагын төлөвлөгөөний хугацаа хэсэгт хэт ерөнхий буюу 1-4 дүгээр улиралд гэж бичснээс шалтгаалж тайлант хугацаа болоогүй гэж үзсэн зарим арга хэмжээ 0 хувиар үнэлгээ хийхэд хүрлээ. Өөрөөр хэлбэл төлөвлөгөөг 3 дугаар улирлаас хойш хэрэгжүүлж эхлүүлэхээр төлөвлөсөн байгууллагын тайланд 1-4 дүгээр улирал гэж тусгаснаар уг төлөвлөгөөний хэрэгжилт хагас жилээр тайлагнагдах ёстой гэж үзсэн болно.

Мөн төлөвлөгөөний биелэлтийг ирүүлж буй албан хаагчид хэт их үгийн товчлол хэрэглэсэн, 2000 тэмдэгтээс хэтэрсэн, хэрэгжилтийн агуулгыг бүрэн илэрхийлж чадаагүй гэх зэрэг асуудлууд байна. Өөрөөр хэлбэл зарим арга хэмжээг хэдий 100 хувиар үнэлгээ хийсэн боловч нэгэнт төлөвлөсөн зорилттоо хүрсэн бол ямар үр дүнд хүрсэн талаар тайлагнах ёстой боловч тайланд зөвхөн жижиг процессын шатны агуулгыг дурдаад өнгөрсөн нь үндсэн зорилтдоо хүрснийг бүрэн илэрхийлж чадахгүй байна. Түүнчлэн байгууллагын төлөвлөгөөний суурь түвшинг тодорхой тавиагүй нь арга хэмжээний үнэлгээг бодитоор тооцоход хүндрэл үүсгэсэн болно.

Мөн сайдын стратеги зорилтоос 8 зорилтыг тус яам хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байх ба эдгээр 8 зорилтод нийцүүлж газар хэлтсийн төлөвлөгөө туссан боловч нэгтгэл хийсэн биелэлтээс аль газар хэлтэс аль арга хэмжээг тайлагнасан, хүний нөөцийн хувьд тухайн газар, хэлтэс хангалттай байгаа эсэх, төлөвлөсөн зорилтыг хэрэгжүүлэх нөөц бололцоо байсан эсэхэд дүгнэлт хийхэд саад учирсан гэж үзлээ.

Өөрөөр хэлбэл яамны төлөвлөгөөний хэдэн хувийг аль газар хариуцан ажиллаж байгаа үр дүнгийн тусламжтайгаар тухайн бодлогыг хэрэгжүүлэх хүний нөөцийн асуудлыг мөн хөндөж удирдлагад танилцуулан шийдвэрлүүлэх боломжтой байсныг онцолж байна. Дээрх асуудлуудаас гадна албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хамаарах нотлох баримт өгөөгүй нь үнэлгээний оноог бууруулахад

нөлөөллөө. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 186 арга хэмжээний хэрэгжилт хэдий 70 хувиас дээш үнэлгээ хийгдсэн боловч үр дүнтэй ажил цөөн бөгөөд ихэнх ажлууд үр дүндээ хүрэхийн тулд эхний хагас жилийн байдлаар бэлтгэл ажлуудаа хангалттай хийж байна гэж үзэхээр байлаа. 1-4 дүгээр улиралд төлөвлөгдсөн арга хэмжээнүүдийн тухайд эхний хагас жилд нь ямар ажлууд хийж гүйцэтгэсэн бол 100 хувь болох нь ойлгомжгүй, мөн тайлан биелэлт хугацаа тулгаж ирсэн гэх зэрэг шалтгаануудыг үндэслэн цаашид авч хэрэгжүүлэх дараах зөвлөмжийг өгч байна.

ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /

Хэрэгжилт хангалтгүй, үр дүнг хангалттай тайлагнаж чадаагүй ажлуудыг 2025 оны сүүлийн хагас жилд эрчимжүүлэхэд анхааран ажиллах шаардлагатай болохыг үүгээр мэдэгдэж, цаашид үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэх дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

Яамны бодлого төлөвлөлтийн болон бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудад:

1. Төрийн захиргааны удирдлагын газар тайлан нэгтгэлийг цаашид Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас тайлантай танилцаж холбогдох баримт материалыг судлан үзэх, үнэлгээ хийх, сайдын зөвлөлийн хуралд танилцуулах зэрэг боломжит хугацааг анхаарч хүлээлгэн өгч хэвших;

2. Бусад нэгжүүд дотроо яамнаас тайлагнадаг баримт бичгүүдийн хэрэгжилтийн биелэлтийг нэгтгэн гаргаж байх албан хаагчдыг тодорхойлж, хариуцах эзэнтэй байхаар зохион байгуулах хэвших;

3. Төсвөөс шалтгаалах ажлын биелэлтийг бодит, дүн шинжилгээтэй, тооцоо судалгаанд үндэслэсэн баримтад тулгуурлан гаргаж хэвших;

4. Ямар эерэг үр дүнд хүрсэн тайлаар бодит нотолгоотой тайлан бичиж ирүүлэх;

5. 2000 тэмдэгтээс хэтрүүлэхгүй, зөв бичгийн алдаагүй, агуулгын хувьд тодорхой, ойлгомжтой, зорьсон үр дүндээ хүрсэн эсэхийг нэгж тус бүр дотооддоо хяналт тавьж, тайлагнаж хэвших;

6. Яамны төлөвлөгөөнд туссан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг ахиулахтай холбоотой нэгжийн удирдлагууд хяналт тавьж ажиллах;

7. Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд дахин давтагдах шинжтэй, байнгын үргэлжилдэг ажлаас илүүтэйгээр үр дүнд хүрэх ажлыг оруулахад анхаарах;

8. Хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагч, ажлын байрны дүн шинжилгээ хийж, чиг үүргийн давхардлыг өөрчлөх, нэгжийн хийж гүйцэтгэх ажил үүргийг орхигдуулсан эсэхийг нягтлах;

Засгийн газрын 43 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчийн эрх үүрэгтэй танилцан хамтран ажиллахыг цаашид анхаарна уу.

Жич: Яамны газар, хэлтсийн дарга нар дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, албан хаагчдаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхэд төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг хийх болохыг үүгээр мэдэгдэж байна.

Мөн эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрхэн ахиулах болон тайлагнах, ирэх онд хэрхэн зөв төлөвлөх талаар талаар яамны Төрийн захиргааны удирдлагын газрын холбогдох албан хаагч, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын албан хаагчдаас тухай бүр зөвлөгөө, дэмжлэг авч ажиллахыг хүсье.